



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМ

ХОТ ТОСГОН БУСАД СУУРИН ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ,
ЧАНАРЫН ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАН БАТАЛГААНЫ АЖЛЫН
ТАЙЛАН

ГҮЙЦЭТГЭГЧ: Газрын
мэргэжлийн
байгууллага

Дижитал мэппинг ХХК
Улаанбаатар хот
2022 он

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ТӨВ

ХОТ ТОСГОН БУСАД СУУРИН ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАН БАТАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Гүйцэтгэсэн: ДИЖИТАЛ МЭППИНГ ХХК

.....Н.Баасанжав, мэргэшсэн газар
зохион байгуулагч, газрын кадастрын инженер
.....Д.Түвшинбаяр Phd, газар зүйн
мэдээллийн системийн мэргэжилтэн
.....П.Ариунсүрэн, PhD ургамал судлаач
.....А.Оюунбаяр, хөрс судлаач

2022 он

ГАРЧИГ

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ -----	10
1.1 Үндэслэл -----	10
1.2 Ажлын зорилго -----	11
ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ -----	13
ХОЁР. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМ -----	15
2.1 Байгаль, цаг уур. газар ашиглалт -----	16
2.2 Байгаль орчныг хамгаалах чиглэлээр авч буй арга хэмжээ-----	18
ГУРАВ. ХОТ СУУРИН ГАЗРЫН АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ -----	18
ДӨРӨВ. ХОТ СУУРИН ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ӨӨРЧЛӨЛТ -----	19
4.1 С62340100001 нэгж талбар ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН-----	44
4.2 С62340100002 нэгж талбар ЦАХИЛДАГТ БҮЛГЭМДЭЛ-----	48
4.3 С62340100003 нэгж талбар ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ -----	50
4.4 С62340100004 нэгж талбар СУМЫН ТӨВИЙН ХОЙД ХЭСЭГ -----	53
4.5 С62340100005 нэгж талбар СУМЫН ТӨВИЙН ХАЛЦГАЙ ГАЗАР-----	58
4.6 С62340100006 нэгж талбар СУРГУУЛЬ-----	61
4.7 С62340100007 нэгж талбар ГОЛЫН ХОЙД ХЭСЭГ -----	64
4.8 С62340100008 нэгж талбар ТҮР ХОГИЙН ЦЭГ, НИЙТИЙН 00–ИЙН ЦЭГ ОРЧИМ ----	66
4.9 С62340100010 нэгж талбар СУМЫН ЗҮҮН УРД ХЭСЭГ -----	69
4.10 С62340100011 нэгж талбар СУМЫН ЗҮҮН УРД ХЭСЭГ -----	73
4.11 С62340100012 нэгж талбар АГУЙТ III ГЭР ХОРООЛОЛ -----	77
4.12 С62340100013 нэгж талбар ХУУЧИН ГЭР ХОРООЛОЛ-----	81
4.13 С62340100014 нэгж талбар ГЭР ХОРООЛОЛ-----	85
4.14 С62340100015 нэгж талбар ГЭР ХОРООЛОЛ-----	88
4.15 С62340100016 нэгж талбар ХОГИЙН ТӨВ ЦЭГ -----	92
4.16 С62340100017 нэгж талбар СУМЫН ТӨВИЙН ЗҮҮН УРД-----	95
ТАВ. МОНИТОРИНГИЙН ЦЭГИЙН МЭДЭЭЛЭЛ-----	100
ЗУРГАА. ХОТ СУУРИН ГАЗРЫГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, ХАМГААЛАХ ШААРДЛАГА ----	102
ДҮГНЭЛТ -----	102
АШИГЛАСАН МАТЕРИАЛ -----	106
НАЙМ. ХАВСРАЛТ МАТЕРИАЛ-----	108

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ажлын даалгавар дахь хийгдэх ажлууд, түүнийг гүйцэтгэх төлөвлөгөө	13
Хүснэгт 2. Эзэмшил газрын хилийн эргэлтийн цэгийн координат	17
Хүснэгт 3. Газар ашиглалтын өөрчлөлт, сүүлийн 5 жил	18
Хүснэгт 4. Хээрийн судалгааны цэгүүд	20
Хүснэгт 5. Ургамалжлын хэв шинж	24
Хүснэгт 6. Ургамалжлын мониторинг	24
Хүснэгт 7. Өлзийт сумын суурьшлын бүсийн ургамлын зүйлийн бүрдлийн бичиглэл	26
Хүснэгт 8. Өлзийт сумын суурьшлын бүсийн талбайн ургамлуудын ангиллын үндсэн бүлгийн бүтэц	31
Хүснэгт 9. Өлзийт сумын суурьшлын бүсийн талбайд бүртгэсэн ургамлын ангиллын бүтэц	32
Хүснэгт 10. Өлзийт сумын суурьшлын бүсийн талбай дахь зүйлийн бүрдлийн онцлог	33
Хүснэгт 11. Өлзийт сумын суурьшлын бүсийн талбайд дахь зүйлийн бүрдлийн онцлог	34
Хүснэгт 12. Хөрсний дээжний шинжилгээний төрөл	35
Хүснэгт 13. Газрын хянан баталгааны үзүүлэлт (агрохими)	36
Хүснэгт 14. Газрын хянан баталгааны үзүүлэлт (Хөрсний эрүүл ахуй)	38
Хүснэгт 15. Худгийн усны эрүүл ахуйн үзүүлэлт	39
Хүснэгт 16. Нэгж талбарт хуваалт	43
Хүснэгт 17. Үетэн-алаг өвс-агьт ургамлан нөмрөгийн төлөв байдал	46
Хүснэгт 18. Үетэн-алаг өвс-агьт бүлгэмдэлийн ургацын бичиглэл	46
Хүснэгт 19. Хөрсний химийн шинж чанар	47
Хүснэгт 20. Хөрсний механик бүрэлдэхүүн	47
Хүснэгт 21. Үетэн-улалж -цахилдаг -алаг өвст ургамлан нөмрөгийн төлөв байдал	49
Хүснэгт 22. Үетэн-улалж -цахилдаг -алаг өвст бүлгэмдэлийн ургацын бичиглэл	50
Хүснэгт 23. Хиаг -алаг өвст ургамлан нөмрөгийн төлөв байдал	51
Хүснэгт 24. Хиаг -алаг өвст бүлгэмдэлийн ургацын бичиглэл	52

Хүснэгт 25. Үетэн-алаг өвс–агьт ургамлан нөмрөгийн төлөв байдал	55
Хүснэгт 26. Үетэн-алаг өвс–агьт бүлгэмдэлийн ургацын бичиглэл.....	56
Хүснэгт 27. Хөрсний морфологи бичиглэл	56
Хүснэгт 28. Хөрсний химийн шинж чанар	56
Хүснэгт 29. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	57
Хүснэгт 30. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн	59
Хүснэгт 31. Хөрсний морфологи бичиглэл	59
Хүснэгт 32. Үетэн –улалж -цахилдаг -алаг өвст ургамлан нөмрөгийн төлөв байдал	62
Хүснэгт 33. Үетэн –улалж -цахилдаг -алаг өвст бүлгэмдэлийн ургацын бичиглэл .	63
Хүснэгт 34. Хээрсэн нугын хөрсний морфологи биичгчлэл	63
Хүснэгт 35. Хөрсний химийн шинж чанар	64
Хүснэгт 36. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	64
Хүснэгт 37. Хиаг–шарилжит ургамлан нөмрөгийн төлөв байдал.....	67
Хүснэгт 38. Хиаг–шарилжит бүлгэмдэлийн ургацын бичиглэл.....	68
Хүснэгт 39. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн	68
Хүснэгт 40. Үетэн–улалж - алаг өвст ургамлан нөмрөгийн төлөв байдал	70
Хүснэгт 41. Үетэн–улалж - алаг өвст бүлгэмдэлийн ургацын бичиглэл.....	71
Хүснэгт 42. Хөрсний морфологи бичиглэл	71
Хүснэгт 43. Хөрсний химийн шинж чанар	72
Хүснэгт 44. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	72
Хүснэгт 45. Үетэн-чулуусаг алаг өвст ургамлан нөмрөгийн төлөв байдал	75
Хүснэгт 46. Үетэн-чулуусаг алаг өвст бүлгэмдэлийн ургацын бичиглэл.....	75
Хүснэгт 47.Хөрсний морфологи бичиглэл	76
Хүснэгт 48. Хөрсний химийн шинж чанар	75
Хүснэгт 49. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	76
Хүснэгт 50. Хог ургамалт үүсмэл бүлгэмдэл төлөв байдал.....	78
Хүснэгт 51. Хог ургамалт үүсмэл бүлгэмдэлийн ургацын бичиглэл.....	79
Хүснэгт 52. Хөрсний морфологи бичиглэл	79
Хүснэгт 53. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн	80
Хүснэгт 54. Үетэн–улалж -хог ургамалт бүлгэмдэл төлөв байдал	82

Хүснэгт 55. Үетэн–улалж -хог ургамалт бүлгэмдэлийн ургацын бичиглэл	82
Хүснэгт 56. Хөрсний морфологи бичиглэл	84
Хүснэгт 57. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн	83
Хүснэгт 58. Хиаг-хог ургамалт бүлгэмдэл төлөв байдал	86
Хүснэгт 59. Хиаг-хог ургамалт бүлгэмдэлийн ургацын бичиглэл	86
Хүснэгт 60. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн	86
Хүснэгт 61. Жижиг улалж -хиаг-хог ургамалт, дэрст бүлгэмдлийн төлөв байдал..	89
Хүснэгт 62. Жижиг улалж -хиаг-хог ургамалт, дэрст бүлгэмдлийн ургацын бичиглэл	89
Хүснэгт 63. Хөрсний морфологи бичиглэл	90
Хүснэгт 64. Хөрсний химийн шинж чанар	91
Хүснэгт 65. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	91
Хүснэгт 66. Хог ургамал -үетэн–агьт бүлгэмдэл төлөв байдал.....	93
Хүснэгт 67. Хиаг-хог ургамалт бүлгэмдэлийн ургацын бичиглэл	93
Хүснэгт 68. Хөрсний химийн шинж чанар	94
Хүснэгт 69. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	94
Хүснэгт 70. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн	94
Хүснэгт 71. Үетэн–чулуусаг алаг өвст ургамлан нөмрөгийн төлөв байдал	96
Хүснэгт 72. Үетэн–чулуусаг алаг өвст бүлгэмдэлийн ургацын бичиглэл.....	97
Хүснэгт 73. Хөрсний химийн шинж чанар	97
Хүснэгт 74. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	97
Хүснэгт 75. Ерхөг -хялгана-агьт бүлгэмдэл төлөв байдал.....	99
Хүснэгт 76. Ерхөг -хялгана-агьт бүлгэмдэлийн ургацын бичиглэл.....	99
Хүснэгт 77. Хөрсний хүнд металл	100
Хүснэгт 78. Өлзийт сумын суурьшлын бүсэд хийсэн хээрийн судалгааны цэгийн солбилцол	100

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төв байршлын ерөнхий схем	15
Зураг 2. Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төв	16
Зураг 3. Өлзийт сумын хиймэл дагуулын зурагнаа	17
Зураг 4, 5. Судалгааны баг, ажлын явц	21
Зураг 6, 7. Өвөрхангай аймгийн Өлзийт сумын суурьшлийн бүс дотор хөрс - ургамлын дээж цуглуулж байгаа нь	21
Зураг 8. Өвөрхангай аймгийн Өлзийт сумын ургамалжлын зураг.....	23
Зураг 9. Хөрсний зураг, “Орхон гидрогео” ХХК.....	35
Зураг 10. Өлзийт сумын төвийн хөрсний тархалт,2022 он	38
Зураг 11, 12. Ундны худаг, Мод усалдаг худаг	39
Зураг 13. Өлзийт сумын хот тосгон бусад суурин газрын хянан баталгааны сүлжээний зураг	41
Зураг 14. Хянан баталгааны 1-р нэгж талбарын зураг.....	44
Зураг 15,16. Ургамлын мониторинг М 1.	45
Зураг 17. Хянан баталгааны 2-р нэгж талбарын зураг.....	48
Зураг 18,19. Ургамлын мониторинг М 6.	49
Зураг 20. Хянан баталгааны 3-р нэгж талбарын зураг.....	50
Зураг 21-23. Ургамлын мониторинг М 3.	52
Зураг 24. Хянан баталгааны 4-р нэгж талбарын зураг.....	53
Зураг 25-27. Ургамлын мониторинг М 4.	55
Зураг 28. Хянан баталгааны 5-р нэгж талбарын зураг.....	58
Зураг 29,30. Ургамлын мониторинг М 5.	59
Зураг 31. Хянан баталгааны 6-р нэгж талбарын зураг.....	61
Зураг 32, 33. Ургамлын мониторинг М 6.	63
Зураг 34. Хянан баталгааны 8-р нэгж талбарын зураг.....	66
Зураг 35-38. Ургамлын мониторинг М 8.	67
Зураг 39. Хянан баталгааны 10-р нэгж талбарын зураг.....	69
Зураг 40-44. Ургамлын мониторинг М 10.	70
Зураг 45. Хянан баталгааны 11-р нэгж талбарын зураг.....	73
Зураг 46,47. Ургамлын мониторинг М 11.	74

Зураг 48. Хянан баталгааны 8-р нэгж талбарын зураг.....	77
Зураг 49,50. Ургамлын мониторинг М 12.	78
Зураг 51. Хянан баталгааны 13-р нэгж талбарын зураг.....	81
Зураг 52,53 Ургамлын мониторинг М 13.	83
Зураг 54. Хянан баталгааны 14-р нэгж талбарын зураг.....	85
Зураг 55,56. Ургамлын мониторинг М 14.	87
Зураг 57. Хянан баталгааны 15-р нэгж талбарын зураг.....	88
Зураг 58,59. Ургамлын мониторинг М 15.	90
Зураг 60. Хянан баталгааны 16-р нэгж талбарын зураг.....	92
Зураг 61,62 Ургамлын мониторинг М 16.	93
Зураг 63. Хянан баталгааны 17-р нэгж талбарын зураг.....	95
Зураг 64,65. Ургамлын мониторинг М 17.	96
Зураг 66. Хянан баталгааны 18-р нэгж талбарын зураг.....	98

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1 ҮНДЭСЛЭЛ

Хот тосгон, бусад барилга, байгууламжийн дэвсгэр газарт тухайн нутаг дэвсгэрт орших иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтын талбай дахь барилга байгууламжийн дэвсгэр болон түүний дагалдах газрууд зам, шугам сүлжээний газар хамаарна.

Монгол улсын Газрын тухай хуульд Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтын бүх газарт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хийж байхаар зааж өгсөн нь, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нар тухайн эдэлбэр газраа цаашид зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хуулийн хүрээнд авч явуулах эрхзүйн орчныг бүрдүүлж байгаа явдал юм. Хуульд заасны пагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа бүх ангиллын газарт төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийснээр уг газрыг улсын хяналтанд авсан анхны үзүүлэлттэй харицуулан дүгнэлт гаргаж тухайн үед байгаль орчны тэнцвэртэй байдалд үзүүлж байгаа буюу цаашид үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг (салхины эвдрэл, усны эвдрэл, шимийн доройтол, цөлжилт, агаар, ус, хөрсний бохирдол гэх мэт) бууруулах, хамгаалах, урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж, улмаар газрын хянан баталгааны байнгын сүлжээг бий болгож, түүнд байнгын хяналт тавьж, нөхөн сэргээлт явуулах, менежментийн нэгдсэн тогтолцоонд шилжихэд ач холбогдолтой.

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын Төлөвлөгөөт хянан баталгааны ажлыг өмнө Газрын Харилцаа Геодези зураг зүйн газрын захиалгаар Газрын мэргэжлийн байгууллага “Геоэкоб” ХХК 2004 онд хийж гүйцэтгэсэн байна.

Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын Төлөвлөгөөт хянан баталгааны ажлыг сумын ЗДТГ-ын захиалгаар тус сумын төвийн тэг гортигийн хүрээнд хот суурин бусад тосгоны газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааг Газрын мэргэжлийн байгууллага “Дижитал мэппинг” ХХК хийж 2022 оны 7 сарын 26-аас 11 сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллалаа.

1.2 АЖЛЫН ЗОРИЛГО

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын газрын төлөв байдал чанарын хянан баталгаа нь гадаргуугийн төрх байдал, хөрс ургамалжилтын хэв шинж, нөлөөллийн төрөл, зэрэглэлийн талаарх хянан баталгааны үндсэн үзүүлэлтийг тодорхойлон дүгнэлт гаргаж, хамгаалах зөвлөмжийг тусгахад оршино. Энэхүү ажлыг гүйцэтгэхэд дараах зорилтуудыг тавьж ажилласан. Үүнд:

- Нийт талбайн газрын гадаргуугийн төрх байдлыг тодорхойлох
- Талбайн хөрсний бүтэц бүрэлдэхүүн, үржил шимийн үзүүлэлтүүдийг тодорхойлж, ангиллыг тогтоох
- Ургамлан нөмрөгийн зүйлийн бүрэлдэхүүн, тусгаг бүрхэц, ургацын үзүүлэлтүүдээр хэв шинжийг тогтоох
- Гадаргуугийн хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдлын талаар үнэлгээ өгөх
- Газар ашиглалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явц дахь хүрээлэн байгаа орчиндоо учруулах сөрөг нөлөөллийг багасгах зэрэг асуудлаар санал дүгнэлт гаргах зэрэг болно.

Ажиллах хүчний бүрэлдэхүүн

Судалгааны хээрийн ажлыг 2022 оны 07 сарын 27-ний өдөр Газар зохион байгуулагч инженер Н.Баасанжав, хөрс судлаач А.Оюунбаяр, ургамал судлаач П.Ариунсүрэн, инженер техникийн туслах ажилтан Д.Өлзийхутаг, суурин боловсруулалтын инженер Д.Түвшинбаяр нарын бүрэлдэхүүнтэй ажиллав.

Бэлтгэл ажлын үед бэлтгэсэн эх зургаа ашиглан хээрийн судалгааг явуулахдаа үндсэн талбайнуудаа нэгж талбайнуудад хуваан хил заагийг тогтоон, зурагт оруулж, талбар тус бүрийн хэмжээг тодорхойлж дүгнэлт гаргалаа. Нэгж талбаруудад хуваахдаа доорх хүчин зүйлүүдийг тооцоолж үзлээ.

- Гадаргуугийн төлөв байдал
- Гаднын хүчин зүйлийн үйлчлэлээр бий болсон хөрсний элэгдэл эвдрэл (бохирдолт, зулгаралт, бохирдолт)
- Ургамлын тусгаг бүрхэц
- Хөрс, ургамлын бүрхэвч зэрэг байгалийн өөрийнх нь унаган төрх байдлыг тооцсоноос гадна ашиглалтын явцад хүний үйл ажиллагааны нөлөөгөөр бий болсон элэгдэл, эвдрэл, бохирдолт зэргийг тооцов.

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Хот тосгон, бусад суурийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийдээ БХБЯ-ны сайдын 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 34 тоот тушаалаар батлагдсан аргачилсан зааврын гуравдугаар хавсралт тусгагдсан арга зүйн дагуу хийж гүйцэтгэлээ..

Хүснэгт 1. Ажлын даалгавар дахь хийгдэх ажлууд, түүнийг гүйцэтгэх төлөвлөгөө


№	Ажлын иж бүрдэл	Гүйцэтгэх үе шат	Гүйцэтгэх хугацаа	Хийгдэх ажлууд	
1	Аймаг, сумын газрын гадарга, уур амьсгал, хөрс, ургамлын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх, зурагт оруулах	Бэлтгэл ажил	2022-7-20	1. Сумын хөрс, ургамал, байр зүйн зургийг газрын даамлаас авч дүн шинжилгээ хийх 2. Сумын байгаль цаг уур, газрын гадаргын талаарх мэдээллийг газрын даамлаас авах	
2	Өмнөх хянан баталгааны ажлын тайлан зураг, шинжилгээний дүнтэй танилцах		2022-7-26	Өмнөх хянан баталгааны ажлын тайлан зургийг газрын даамлаас авах, шинжилгээний дүнтэй танилцах	
3	Өмнөх хянан баталгааны мониторингийн болон хөрс ургамлын дээж авсан цэгийн байршлыг солбицлын дагуу оруулах		2022-7-26	Өмнөх хянан баталгааны мониторингийн болон хөрс ургамлын дээж авсан цэгийн байршлыг солбицлын дагуу оруулах	
4	10 метрийн нарийвчлалтай сансрын зургийг боловсруулж, бэлтгэх		2022-7-30	Sentinel2 хиймэл дагуулын сүүлийн 5 жилийн мэдээг татаж боловсруулалт хийх	
5	Газрын кадастрын мэдээллийн санд байгаа кадастрын зургийг сансрын зурагтай тулган шалгах		2022-7-27	Газрын кадастрын мэдээллийн санд байгаа кадастрын зургийг SAS Planet сансрын зурагтай тулган шалгах	
6	Газрын нэгдмэл сангийн зургийг сансрын зурагтай тулган шалгах		2022-7-27	e-gazar.gov.mn цахим систем дэх газрын нэгдмэл сангийн зургийг сансрын зурагтай шалгах	
7	Хот суурин газар тэлсэн байдлыг тодорхойлох		Материал боловсруулалтын	2022-8-27	gazar.gov.mn цахим систем дэх газрын нэгдмэл сангийн тайлангуудыг сүүлийн 5 жилийн байдлаар судлах
8	Хянан баталгааны үндсэн нэгж талбар			2022-7-26	Газрын даамал Б.Гансүхээс санал авах

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

	болон дэд нэгж талбарыг нарийвчлан тодорхойлох, сумын газрын даамлуудаас санал авах	Талбайн буюу хээрийн судалгааны		Газар ашиглалтын онцлог, төлөв байдлыг урьдчилэн тогтоох
9	Хөрсний элэгдэл, эвдрэлийн байдлыг тогтоох		2022-7-26	Газар дээр нь тогтоох
10	Газрын физик, хими, биологийн бохирдолд орсон талбайг тодорхойлох		2022-7-26	Газар дээр нь тогтоох
11	Мониторингийн цэг бүрээр хувийн хэрэг үүсгэх		2022-10-26	Мониторингийн цэг бүрээр хувийн хэрэг үүсгэх
12	Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг хийх, холбогдох загварын дагуу мэдээллийн сан үүсгэх	Материал боловсруулалтын	2022-10-26	Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг хийх, холбогдох загварын дагуу мэдээллийн сан үүсгэх
13	Нэгж талбар бүрээр хянан баталгааны дүгнэлт, зөвлөмж боловсруулах		2022-11-10	Нэгж талбар бүрээр хянан баталгааны дүгнэлт, зөвлөмж боловсруулах

ХОЁР. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМ

Өвөрхангай аймгийн Өлзийт сум нь 1931 онд байгуулагдсан. Хуучнаар Сайн ноён хан аймгийн Илдэн бээлийн хошуу. Тус сум нь Борхошуу, Агуйт, Яргайт, Гуулин гэсэн 4 багтай. Нийт 764 өрхөд 2472 хүн амьдардаг. Хүн амын тоогоор сүүлээсээ 5-д газар нутгийн хэмжээгээр 10-т ордог. Өвөрхангай аймгийн Зүүн Хойд хэсэгт Есөнзүйл, Сант, Баян-Өндөр, Зүүнбаян-Улаан, Хужирт зэрэг сумтай хил залгаа оршдог.



Зураг 1. Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төв байршлын ерөнхий схем



Зураг 2. Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төв

2.1 БАЙГАЛЬ, ЦАГ УУР. ГАЗАР АШИГЛАЛТ

Газрын гадарга: Сумын төвийн дундаж өндөр нь далайн төвшинөөс 1877м, хамгийн өндөр цэг нь 1885м, хамгийн нам цэг нь 1872м юм. Сумын төвийн тосгоны газрын гадарга нь тэгширтэр, ерөнхий налуу нь 1° - 3° байдаг. Сумын төвийн дэвсгэр газрыг экологийн 3 бүлэгт хувааж болох ба нам болон дундаж өндөртэй толгод, тэгш тал, голын хөндий гэсэн 3 бүсэд болно. Сумын төвийн тэгш тал хөндийгөөр барилгажсан хэсэг, гэр хороолол бүгд байрладаг.

Уур амьсгал: Өлзийт сумын төв нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, хоногийн ба жилийн халуун хүйтний хэлбэлзэл ихтэй. Уур амьсгалын үзүүлэлтийг авч үзвэл сарын агаарын дундаж температур 1 сард 17,5 хэм хүйтэн, 7-р сард 21,1 хэм дулаан, жилийн дундаж дулаан 1,2 хэм байдаг байна. Уур амьсгалын хувьд хуурай, гандуу жилдээ 165мм тунадас унадаг. Хөрсөн бүрхэвч нимгэн, амьтан, ургамлын тоо цөөн байдаг.

Ургамлан нөмрөг: Тус сумын төвийн хойт, баруун хойт, баруун хэсгээр нам толгод бүхий газруудаар хялгана-хазаар өвст, тал хөндийгөөр шарилж-хазаар өвст төрөл, сумын төвийн зүүн хэсэг шарилж-агьт, хазаарт бүлгэмдлүүд тархана. Энд хялгана, хазаар өвст, агь, шарилж, нэг наст бударгана зэрэг ургамал зонхилно. Зам дагуу хамхуул, лууль, адамсын шарилж, хамхаг зэрэг хөл газрын ургамал

ургасан байна. Ургамал нөмрөг нь талхлагдаж лууль, шарилж, хамхуул зэрэг ургамал 50-60%-ийг эзэлж байна.

Хөрсөн бүрхэвч: Тус сумын төв нь хөрсний төрлийн хувьд цөлөрхөг, хээрийн элсэнцэр цайвар хүрэн хөрс ноёрхох бөгөөд сумын тосгоны хилийн захын цэгүүдээр уул, толгодын цайвар хүрэн хөрс давамгайлна. Суурьшлын бүсийн бүх хэсэгт хийсэн хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдлын бичиглэлээс үзэхэд сумын төвийн цэцэрлэг, мод зүлэг суулгасан газраас бусад газрууд автогений нөлөөгөөр нилээд элэгдэлд орж, хайргархаг хэсэг нь ил гарсан байна гэж 2004 оны газхын хянан баталгааны тайланд дурьджээ.



Зураг 3. Өлзийт сумын хиймэл дагуулын зурагнаа

Нэгж талбар нь нийт 5 эргэлтийн цэгтэй 3237400.9 м² газарт өнөөдөр үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 2. Эзэмшил газрын хилийн эргэлтийн цэгийн координат

Эргэлтийн цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг	Цэгийн нэр
1	103° 31' 59.456"	46° 36' 35.587"	Цагаан хошуу
2	103° 33' 0.686"	46° 37' 11.731"	Улаан хошуу
3	103° 33' 53.281"	46° 36' 41.532"	Улаан дэл
4	103° 34' 10.630"	46° 36' 9.171"	Хар толгой
5	103° 33' 2.332"	46° 36' 5.226"	Жавхлант

2.2 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын Засаг даргын тамгын газраас сумынхаа байгаль орчныг хамгаалах, хүн ардаа эрүүл орчинд амьдрах нөхцлөөр хангахад багагүй арга хэмжээг авдаг. Түүний тод жишээ бол байгууллага бүр гадна талаа цэцэрлэгжүүлж мод тарихаас гадна сумын иргэд өөрийн санаачлагаар хашаандаа мод тарьсан байна. Сумын хэмжээнд ногоон байгууламжийн талбай 0,56 га байна. Үүнд:

1. Сумын төвийн цэцэрлэгт хүрээлэн-2810 м²
2. Сумын төвийн ард байгуулсан шинэ цэцэрлэгт хүрээлэн -245231,6 м²

Эдгээр цэцэрлэгт хүрээлэн болон сургууль, цэцэрлэг, соёлын төв, эмнэлгийн гаднах хашаанд 277 ширхэг улиас, 136 ширхэг бургас, 1429 ширхэг хайлас, 4 ширхэг шинэс, 10 ширхэг чацаргана, 3 ширхэг голбор нийт 6 төрлийн 1859 ширхэг мод ургаж байна.

ГУРАВ. ХОТ СУУРИН ГАЗРЫН АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Өлзийт сумын хот, тосгон, бусад суурины газар нь сүүлийн 5 жилд онцын өөрчлөлтгүй нэг ангиллын газар нөгөө ангилал руу шилжих замаар дотроо шилжиж байгааг тус сумын газрын нэгдмэл сангийн тайлангаас (Хүснэгт 3) харж болно [17]. Жишээлбэл 2017 оноос 2018 онд барилга байгууламжийн дэвсгэр газрын хэмжээ 0,1 га-аар нэмэгдэж, нийтийн эдэлбэр газар 1,11 га-аар хорогдож, гэр хорооллын газар 1,01 га-аар нэмэгдсэн байна. Харин 2018 оноос 2019 онд барилга байгууламжийн дэвсгэр газрын хэмжээ 0,28 га-аар нэмэгдэж, нийтийн эдэлбэр газар 0,99 га-аар хорогдож, гэр хорооллын газар 0,71 га-аар нэмэгдснээс хойш 2021 оны эцсийн тайлангаар ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна.

Хүснэгт 3. Газар ашиглалтын өөрчлөлт, сүүлийн 5 жил

онууд	Нийт, га	Барилга байгууламжийн дэвсгэр газар, га	Нийтийн эдэлбэрийн газар, га	Гэр хорооллын газар, га
2017	666,10	14,31	639,19	11,6
2018	666,10	14,41	638,08	12,61
2019	666,10	14,69	637,09	13,32
2020	666,10	14,69	637,09	13,32
2021	666,10	14,69	637,09	13,32
2017-2018		0,1	-1,11	1,01
2018-2022		0,28	-0,99	0,71

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан




График 1,2. Газар ашиглалтын өөрчлөлт, сүүлийн 5 жил Өлзийт сумын төвийн газар ашиглалтын өнөөгийн байдлыг харахад 9 зориулалтаар ашиглах бөгөөд 85,6% нь гэр хорооллын газар байна.

Хүснэгт 4. Газар ашиглалт, 2022 он

№	Газар ашиглалтын төрөл	Талбай, м ²	эзлэх хувь
1	Гэр, орон сууцны хашааны газар	83900,91	85,6
2	Эрүүл мэндийн төв	339,11	0,3
3	Шатахуун түгээх газар	1979,51	2,0
4	Хүүхдийн цэцэрлэг	464,81	0,5
5	Сургууль	4013,62	4,1
6	Соёлын төв	668,69	0,7
7	Ногоон байгууламж	6291,27	6,5
8	Захиргаа	323,74	0,3
9	Худалдаа, олон нийтийн	38,15	0,0
	Нийт	98019,81	100,0

ДӨРӨВ. ХОТ СУУРИН ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ӨӨРЧЛӨЛТ

Хээрийн судалгааны болон материал боловсруулалтын үед сумын төвийн эдэлбэр газрын төлөв байдал, ашиглалт чанарын өөрчлөлт, зэргийг шалгуур үзүүлэлтээр газар дээр нь явж, ажиглалт судалгаа явуулан, судалгааны голлох талбараас хөрсний зүсэлт бичиглэл хийн дээж авч лабораторын задлан шинжилгээ хийлээ. Бид Өвөрхангай аймгийн Өлзийт сумын суурьшлын бүсийн хөрс-ургамлан нөмрөгийн төлөв байдлыг илрүүлэх судалгааны ажлын хүрээнд хээрийн судалгааг 2022 оны 7-р сарын 26, 27-ны өдрүүдэд гүйцэтгэж гүйцэтгэж, нийт 18 цэгт ургамлын төрөл, зүйл бүртгэж, ургамлан нөмрөгийн ургамалжлын бичиглэл хийж, хөрсний дээж, 2 худгийн усны шинжилгээний дээж авч хээрийн судалгааны материал цуглуулав.

Хүснэгт 4. Хээрийн судалгааны цэгүүд

Бичиглэлийн цэгийн дугаар	Өргөрөг	Уртраг	Өндөр	Хээрийн тэмдэглэл
М 1	46°36'36.15'';	103°32'53.85'';	h 1812	Цэцэрлэгт хүрээлэн
М 2	46°36'36.00''	103°32'52.68'';	h 1822	Соёлын төв
М 3	46°36'38.15''	103°32'56.96'';	h 1822	Цэцэрлэг
М 4	46°36'42.23''	103°32'51.93''	h 1808	2022 онд байгуулсан шинэ цэцэрлэгт хүрээлэн
М 5	46°36'42.23''	103°32'53.8''	h 1821	Сумын төвийн халцгай газар
М 6	46°36'36.77''	103°32'48.85'';	h 1817	Хээржсэн нугын бүлгэмдэл
М 7	46°36'35.04''	103°32'46.64''	h 1814	Сургууль
М 8	46°36'32.9'';	103°32'45.33'';	h 1817;	Нийтийн 00-ийн цэг орчим
М 9	46°36'32.6'';	103°32'52.26'';	h 1820;	Эрүүл мэндийн төв
М 10	46°36'31.39'';	103°32'48.4'';	h 1821;	Сумын төвийн урд хэсэг
М 11	46°36'35.81'';	103°32'36.22'';	h 1805;	Сумын төвийн зүүн хэсэг
М 12	46°36'37.6'';	103°32'19.24'';	h 1798;	Агуйт гэр хороолол
М 13	46°36'43.79'';	103°32'03.06'';	h 1829;	Хуучин гэр хороолол
М 14	46°36'40.94'';	103°32'17.96'';	h 1813;	Гэр хороолол I
М 15	46°36'40.94'';	103°32'17.96'';	h 1813;	Гэр хороолол II
М 16	46°36'42.79'';	103°32'58.41'';	h 1875;	Хогын цэг
М 17	46°36'29.14'';	103°32'28.96'';	h 1835;	Сумын баруун урд, гэр хороолол

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

М 18	46°36'19.65";	103°32'33.05":	h 1838;	Шатахуун түгээх станц
------	---------------	----------------	---------	-----------------------

Энэхүү 18 мониторингийн цэг нь экологи болон газар ашиглалтын хувьд өөр бөгөөд газрын хянан баталгааны үндсэн нэгж талбар болгон хуваах үндэслэл болж байгаа юм.



Зураг 4, 5. Судалгааны баг, ажлын явц




Зураг 6, 7. Өвөрхангай аймгийн Өлзийт сумын суурьшлийн бүс дотор хөрс - ургамлын дээж цуглуулж байгаа нь



Ургамлан нөмрөгийн төлөв байдал

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын суурьшлын бүсийн 323,8 га талбайд ургамалжлын 18 бичиглэл хийхэд үндсэн бүлгэмдэл нь Үетэн–улалж-хог ургамалт 53,5 га, Хиаг-хог ургамалт 8,9 га, Жижиг улалж-хиаг-хог ургамалт, дэрст 40.1 га, Хог ургамал -үетэн–агьт 1,2 га, Үетэн–чулуусаг алаг өвст 102.1 га, Ерхөг -хялгана-агьт 4.1 га байна.

Өлзийт сумын суурьшлийн бүсийн газрын гадаргын төрх байдлын хувьд ландшафтын ялгарлаар уулын Ерхөг-хялгана-агьт 4.1 га, уул хоорондын хоорондын хөндийн нугын Үетэн–улалж-алаг өвст 33.0 га, хээрийн цэвэр өвслөг ургамалтай. Үетэн-алаг өвс–агьт бүлгэмдэл 24,8 га, бүс дундын Үетэн–улалж -цахилдаг -алаг өвст нугын 27,9 га талбай байна.



Зураг 8. Өвөрхангай аймгийн Өлзийт сумын ургамалжлын зураг

Өлзийт сумын төвийн нийт талбайн 37,6% нь хог ургамалтай, 31,5% нь чулуулаг бүрхэцтэй, 3,0% ургамалан нөмрөггүй болсон нь газрын доройтолд орсны шинж харагдаж байна.

Хүснэгт 5. Ургамалжлын хэв шинж

Нэгж талбарын дугаар	Ургамалжлын хэв шинж	Талбай, га	Эзлэх хувь
C62340100007	Ерхөг -хялгана-агьт	4,1	1,3
C62340100015	Жижиг улалж -хиаг-хог ургамалт, дэрст	40,1	12,4
C62340100005	Ургамлан нөмрөггүй болсон газар	9,8	3,0
C62340100004	Үетэн-алаг өвс-агьт	24,8	7,7
C62340100010	Үетэн-улалж - алаг өвст	33,0	10,2
C62340100013	Үетэн-улалж -хог ургамалт	53,5	16,5
C62340100002	Үетэн-улалж -цахилдаг -алаг өвст	27,9	8,6
C62340100017	Үетэн-чулуусаг алаг өвст	102,1	31,5
C62340100003	Хиаг -алаг өвст	0,2	0,1
C62340100014	Хиаг-хог ургамалт	8,9	2,7
C62340100008	Хиаг-шарилжит, Үетэн-улалж -цахилдаг	0,1	0,0
C62340100016	Хог ургамал -үетэн-агьт	1,2	0,4
C62340100012	Хог ургамалт үүсмэл бүлгэмдэл	18,2	5,6
	Нийт	323,8	100,0

Тус суурьшлийн бүсийн ургамлан нөмрөгийн 100 м² талбайд 7-33 (53) зүйл, 1м² талбайд 5 -10 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлын тусгаг бүрхэц ууландаа 46.0%, хээрээр 55.6-85.0%, нугархаг газраар 61.6 -80.6%, га-ийн ургац ууландаа 2.01 центнер, хээрээр 1.902-2.292 центнер нугадаа 2.19 -4.014 центнер байна.

Хүснэгт 6. Ургамалжлын мониторинг

ID	Ургамлан нөмрөгийн хэв шинж	Ургамалжлын шалгуур үзүүлэлт							
		Зүйлийн тоо (100м ² талбайд)	Зүйлийн тоо (1м ² талбайд)	Ургамлын бүрхэц, %	Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хад, хайрга, чулуу, %	Хагд, %	Ургац, ц/га
М 1	ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН								
	Үетэн-алаг өвс-агьт (128/Х-II-2-7)	25-53	8-10	85.0	4.4	15.0	-	-	1.902
М 2	СОЁЛЫН ТӨВ								
	Хялгана-улалж-агьт	-	-	-	-	-	-	-	-
М 3	ЦЭЦЭРЛЭГ								
	Үетэн-шарилжит	15-28	6-8	73.6	24.0	26.4	-	-	3.466
М 4	2022 ОНД БАЙГУУЛСАН ШИНЭ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН								

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

	Улалж-үетэн-алаг өвст	20-42	8-10	61.6	15.2	33.6	5.8	-	2.19
М 5	СУМЫН ТӨВ ХЭСЭГ, ХАЛЦГАЙ ГАЗАР								
	Ургамлан нөмрөггүй болсон газар	-	-	-	-	-	-	-	-
М 6	ЦАХИЛДАГТ БҮЛГЭМДЭЛ								
	Үетэн-улалж -цахилдаг -алаг өвст (202 /Н-II-2-2)	12-13	5-6	80.6	8.2	19.4	-	-	4.014
М 7	СУРГУУЛЬ								
	Үетэн-алаг өвс-агьт (128/Х-II-2-7)	-	-	-	-	-	-	-	-
М 8	ТҮР ХОГИЙН ЦЭГ, НИЙТИЙН 00-ИЙН ЦЭГ ОРЧИМ								
	Хиаг-шарилжит, Үетэн-улалж -цахилдаг -алаг өвст (121а -202 /Х- II-1-1; Н-II-2-2)	15-20	6-8	72.4	30.8	18.6	9.0	-	2.214
М 9	ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ								
	Үетэн-алаг өвс-агьт (128/Х-II-2-7)	-	-	-	-	-	-	-	-
М 10	М 10. СУМЫН ТӨВИЙН УРД ХЭСЭГ								
	Үетэн-улалж - алаг өвст (85 /УХ- II-2-1)	12	5-8	72.0	11.2	26.2	1.8	-	1.874
М 11	СУМЫН ТӨВИЙН ЗҮҮН ХЭСЭГ								
	Үетэн-чулуусаг алаг өвст (128 /Х-II-2-7)	18-19	7-8	61.8	3.2	25.4	12.8	-	2.292
М 12	АГУЙТ III ГЭР ХОРООЛОЛ								
	Хог ургамалт үүсмэл бүлгэмдэл	8	6-8	52.2	52.2	42.4	5.4	-	4.074
М 13	ХУУЧИН ГЭР ХОРООЛОЛ								
	Үетэн-улалж -хог ургамалт	15-19	8-10	75.0	54.0	19.0	6.0	-	4.13
М 14	ГЭР ХОРООЛОЛ								
	Хиаг-хог ургамалт (121а/Х-II-1-1)	11	6-8	48.6	36.6	51.4	-	-	3.75
М 15	ГЭР ХОРООЛОЛ								
	Жижиг улалж -хиаг-хог ургамалт, дэрст (120а-216/Х-II-1-1; Н-III-1-3)	11	6-8	73.2	16.6	26.8	-	-	4.468
М 16	ХОГИЙН ЦЭГ								
	Хог ургамал -үетэн-агьт (128b/Х-II-2-7)	13	6-8	61.0	46.6	30.8	8.2	-	3.492
М 17	СУМЫН БАРУУН УРД ХЭСЭГ, ГЭР ХОРООЛОЛ								
	Үетэн-чулуусаг алаг өвст (128 /Х-II-2-7)	15-28	6-8	55.6	24.0	29.8	14.6	-	3.12
М 18	ШАТАХУУН ТҮГЭЭХ ГАЗАР								
	Ерхөг-хялгана-агьт (53/Х-II-1-1)	11	6-8	46.0	7.0	43.0	11.0	-	2.01

Зүйлийн бүтэц бүрэлдэхүүний баялаг. Бид судалгааны талбайд нийт 30 овог, 71 төрөл, 91 зүйл бүртгэв (хүснэгт 7).

Хүснэгт 7. Өлзийт сумын суурьшлын бүсийн ургамлын зүйлийн бүрдлийн бичиглэл

№	Овог, төрөл, зүйлийн шинжлэх ухааны нэр	Зүйлийн арев (Друдегийн үнэлгээгээр)	Судалгааны цэг
1	<i>Pinaceae</i> Lindl. -Нарсны		
1	<i>Larix</i> Mill. -Шинэс		
1	<i>Larix sibirica</i> Ldb.- Сибирь шинэс	Тарьмал	1
2	<i>Gramineae</i> Juss. -Үетэний овог		
2	<i>Achnatherum</i> P. B.		
2	<i>Achnatherum splendens</i> (Trin.) Nevski- Гялгар дэрс	Cop ¹	1, 3, 13, 15
3	<i>Stipa</i> L.		
3	<i>Stipa Krylovii</i> Roshev.-Крыловын хялгана	Cop ³	1, 4, 10, 11, 16, 17
4	<i>Calamagrostis</i> Adans.		
4	<i>Calamagrostis macilenta</i> (Griseb.)Litv.- Нарийн ворвоо	Cop ¹	1
5	<i>Cleistogenes</i> Keng.		
5	<i>Cleistogenes squarrosa</i> (Trin.)Keng.- Дэрвээн хазаар өвс	Cop ¹	1, 3, 4, 16, 17
6	<i>Koeleria</i> Pers.		
6	<i>Koeleria macrantha</i> (Ldb.) Schult.-Том цэцэгт дааган сүүл	Cop ¹	1, 4, 10, 11, 17
7	<i>Poa</i> L.		
7	<i>Poa pratensis</i> L.-Нугын биелэг өвс	Cop ¹	1, 6, 8
8	<i>Poa botryoides</i> Trin.-Цацаглаг биелэг өвс	Cop ¹	1, 3, 4, 10, 11
8	<i>Festuca</i> L.		
9	<i>Festuca lenensis</i> Drob.-Ленийн ботууль	Cop ¹	4, 11
9	<i>Hordeum</i> L.		
10	<i>Hordeum brevisubulatum</i> (Trin.) link.- Ахарсорт арвай	Sol	6, 8, 13, 14
10	<i>Bromus</i> L.		
11	<i>Bromus inermis</i> Leyss.-Соргүй согоовор	Cop ²	1
11	<i>Agropyron</i> Gaertn.		
12	<i>Agropyron cristatum</i> (L.) P.B.-Саман ерхөг	Cop ²	1, 3, 4, 6, 8, 10, 11, 13, 16, 17
12	<i>Elytrigia</i> Desv.		
13	<i>Elytrigia repens</i> (L.) Desv. ex Nevski.- Мөлхөө хиаг	Cop ¹	1, 3, 4, 6, 8, 10, 12, 13, 14, 15, 16, 17
13	<i>Elymus</i> L.		
14	<i>Elymus sibiricus</i> L.- Сибирь цагаан суль	Cop ¹	1, 3

3	Cyperaceae Juss. - Улалжийн овог		
14	<i>Carex</i> L.		
15	<i>Carex duriuscula</i> C.A.Мей.-Ширэг улалж	Сор ³	1, 6, 8, 13, 15, 16
4	Alliaceae L. –Сонгинын овог		
15	<i>Allium</i> L.		
16	<i>Allium prostratum</i> Trev.- Дэлхээ сонгино	Sol	4
17	<i>Allium eduardii</i> Stearn.-Эдуардын сонгино	Sol	1
5	Iridaceae Juss.-Цахилдагны овог		
16	<i>Iris</i> L.		
18	<i>Iris lactea</i> Pall.- Цагаалин цахилдаг	Sol	6, 8, 13
6	Salicaceae Mirb. –Бургасны оог		
17	<i>Salix</i> L.		
19	<i>Salix pseudopentandra</i> Flod.- Хуурамч таван дохиурт бургас	Тарьмал	1, 3, 4
20	<i>Salix Miyabeana</i> Seemen.-Миабейн бургас	Тарьмал	1, 4
18	<i>Populus</i> L.		
21	<i>Populus suaveolens</i> Fisch.-Анхилуун улиас	Тарьмал	1, 3, 4
7	Ulmaceae Mirb. – Хайласны овог		20
19	<i>Ulmus</i> L.		
22	<i>Ulmus pumila</i> L.-Одой хайлас	Тарьмал	1, 3, 4
8	Oleaceae Lindl. –Чидуны овог		
20	<i>Syringia</i>		
23	<i>Syringia josikaea</i> Jacq. F. –Мажаар голтбор	Тарьмал	3
9	Aseraceae Lindl. – Агчны овог		
21	<i>Aser</i> L.		
24	<i>Aser negundo</i> L. –Яшил навчит агч	Тарьмал	1
10	Urticaceae Juss. –Халгайн овог		
22	<i>Urtica</i> L.		
25	<i>Urtica cannabina</i> L.-Олслиг халгай	Сор ¹	3, 12, 14, 16
11	Polygonaceae Juss. - Тарнын овог		
23	<i>Rheum</i> L.		
26	<i>Rheum undulatum</i> L.-Долгионтсон гишүүнэ	Sol	16
24	<i>Polygonum</i> L.		
27	<i>Polygonum angustifolium</i> Pall.- Нарийн навчит тарна	Sol	1, 4
	<i>Polygonum aviculare</i> L.-Шувуун тарна	Sol	3
12	Chenopodiaceae Vent. - Луулийн овог		
25	<i>Chenopodium</i> L.		
28	<i>Chenopodium album</i> L-Цагаан лууль	Сор ²	3, 12, 13, 14, 15
26	<i>Corispermum</i> L.		

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

29	<i>Corispermum declinatum</i> Steph.-Өнхрүүш хамхуул	Cop ²	3, 12, 13, 14, 15
27	<i>Salsola</i> L.		
30	<i>Salsola pestifera</i> Nels.-Өргөст бударгана	Sol	4
28	<i>Axyris</i> L.		
31	<i>Axyris prostrata</i> L. - Дэлхээ алиц	Cop ³	6, 8, 12, 13, 14, 15
13	<i>Caryophyllaceae</i> Juss. –Баширын овог		
29	<i>Arenaria</i> L.		
32	<i>Arenaria capillaris</i> Poir.-Хялгасан дэвхэргийн цагаан	Sol	1, 4, 11, 17
30	<i>Silene</i> L.		
33	<i>Silene repens</i> Patr.- Мөлхөө шээрэнгэ	Sol	1
14	<i>Ranunculaceae</i> Juss. - Холтсонцэцэгийн овог		
31	<i>Pulsatilla</i> Mull.		
34	<i>Pulsatilla Bungeana</i> C.A.Mey.-Бунгийн яргуй	Sol	4
15	Тоонолжин цэцэгтэний овог (<i>Cruciferae</i> Juss.)		
32	<i>Lepidium</i> L.		
35	<i>Lepidium ruderales</i> L.-Хогийн цангуу	Cop ¹	1, 8, 12, 13
33	<i>Dontostemon</i> Andrz.		
36	<i>Dontostemon integrifolius</i> (L.) C.A.Mey - Бүхэл навчит багдай	Sol	1, 13
34	<i>Arabis</i> L.		
37	<i>Arabis pendula</i> L.-Санжгар шувтаахай	Cop ¹	9
16	<i>Crassulaceae</i> DC.- Зузаалайн		
35	<i>Orostachys</i> Fisch.		
38	<i>Orostachys malacophylla</i> (Pall.) Fisch.- Зөөлөн навчит үлд өвс	Sol	1
17	<i>Saxifragaceae</i> Juss.- Сэрдэгийн		
36	<i>Ribes</i> L.		
39	<i>Ribes pulchellum</i> Turcz.- Гоо улаалзгана	Sol	1
18	<i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог		
37	<i>Potentilla</i> L.		
40	<i>Potentilla anserina</i> L.-Галуун гичгэнэ	Cop ³	3, 6, 8
41	<i>Potentilla bifurca</i> L.-Имт гичгэнэ	Cop ¹	1, 8, 10
42	<i>Potentilla tanacetifolia</i> Willd.ex Schlecht.- Марал навчит гичгэнэ	Cop ¹	1
43	<i>Potentilla sericea</i> L.-Торгон гичгэнэ	Sol	4, 11
38	<i>Sibbaldianthe</i> Juz.		
44	<i>Sibbaldianthe adpressa</i> (Vge.)Juz.-Налчгар хэрээн хошуу	Cop ¹	4, 10, 11
39	<i>Chamaerhodos</i>		
45	<i>Chamaerhodos altaica</i> (Laxm.) Vge.-Алтайн	Sol	4

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

	ТҮМЭН ТАНА		
46	<i>Chamaerhodos erecta</i> (L) Вге.-Цэх түмэн тана	Sol	1, 13
40	<i>Sanguisorba</i> L.		
47	<i>Sanguisorba officinalis</i> L.-Эмийн сөд	Sol	1
19	Leguminosae Juss. - Буурцагтаны овог		
41	<i>Thermopsis</i> R. Br.		
48	<i>Thermopsis lanceolata</i> R.Br.-Юлдэн тарваган шийр	Sol	1
42	<i>Medicago</i> L.		
49	<i>Medicago falcata</i> L.- Шар царгас	Cop ¹	1, 3
43	<i>Caragana</i> Lam.		
50	<i>Caragana arborescens</i> Lam.-Шар хуайс	Тарьмал	1, 3
51	<i>Caragana pugnata</i> (L.) DC.-Тарваган харгана	Sol	4
44	<i>Astragalus</i> L.		
52	<i>Astragalus galactites</i> Pall.-Цагаан хунчир	Sol	4, 10
53	<i>Astragalus adsurgens</i> Pall.-Нумраа хунчир	Sol	1
54	<i>Astragalus mongolicus</i> Вге.- Монгол хунчир	Sol	1
45	<i>Oxytropis</i> DC.		
55	<i>Oxytropis filiformis</i> DC.- Утсан ортууз	Sol	4
20	Elaeagnaceae Juss. - Жигдийн овог		
46	<i>Hippophae</i> L.		
56	<i>Hippophae rhamnoides</i> L.-Яшилдуу чацаргана	Sol	1
21	Umbelliferae Juss. – Шүхэртэний овог		
47	<i>Sphallerocarpus</i> Bess. ex DC.		
57	<i>Sphallerocarpus gracilis</i> (Bess. ex Trev.) K.- Pol. - Өндөр үхэр гоньд	Cop ¹	3
48	<i>Carum</i> L.		
58	<i>Carum buriaticum</i> Turcz. – Буриад гоньд	Cop ¹	1, 14
49	<i>Bupleurum</i> L.		
59	<i>Bupleurum bicaule</i> Helm. - Хоёр ишт бэриш	Cop ¹	4, 11
60	<i>Bupleurum scorzonifolium</i> Willd. - Хависхана навчит бэриш	Sol	1
50	<i>Peucedanum</i> L.		
61	<i>Peucedanum hystrix</i> Вге. – Шивүүрт жав	Sol	1, 4
22	Primulaceae Vent. – Хаварсалын овог		
51	<i>Androsace</i> L.		
62	<i>Androsace septentrionalis</i> L. -Умардын далан товч	Sol	1
52	<i>Glaux</i> L.		

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

63	<i>Glaux maritima</i> L.- Марзны цэгээлж	Cop ¹	6, 8
23	<i>Gentianaceae</i> Juss. – Дэгдийн овог		
53	<i>Gentiana</i> L.		
64	<i>Gentiana decumbens</i> L.- Хэвтээ дэгд	Sol	1, 4
24	<i>Boraginaceae</i> Juss. - Ноцоргонын овог		
54	<i>Lappula</i> Fabr.		
65	<i>Lappula intermedia</i> (Ldb.) M.Рор.- Завсрын ноцгоно	Cop ¹	8, 12, 13, 14, 15
25	<i>Labiaceae</i> Lindl.- Уруул цэцэгтэний овог		
55	<i>Scutellaria</i> L.		
66	<i>Scutellaria scordifolia</i> Fisch ex Schrank - Царсан гүүн хөх	Sol	1
56	<i>Lophanthus</i> Adans.		
67	<i>Lophanthus chinensis</i> (Raf.) Benth. -Нангиад садагнагва		13
57	<i>Dracosephalum</i> L.		
68	<i>Dracosephalum origanoides</i> Steph. Ex Willd. - Хахуундуу шимэлдэг	Sol	4
58	<i>Panzeria</i> Moench.		
69	<i>Panzeria lanata</i> (L.) Vge. - Үсхий нохойн хэл	Sol	4, 13
59	<i>Thymus</i> L.		
70	<i>Thymus dahuricus</i> Serg.- Дагуур ганга	Cop ¹	4, 11
26	<i>Scrophulariaceae</i> Juss. –Иршимбийн овог		
60	<i>Veronica</i> L.		
71	<i>Veronica incana</i> L. - Буурал гандбадраа	Sol	1
61	<i>Pedicularis</i> L.		
72	<i>Pedicularis flava</i> Pall.- Шар хувилгана	Sol	4
62	<i>Cymbaria</i> L.		
73	<i>Cymbaria dahurica</i> L.- Дагуур хатны цэцэг	Sol	4
27	<i>Plantaginaceae</i> Juss. - Тавансалааны овог		
63	<i>Plantago</i> L.		
74	<i>Plantago depressa</i> Willd.- Замын таван салаа	Cop ¹	6, 8
28	<i>Rubiaceae</i> Lindl. – Ягаандайн овог		
64	<i>Galium</i> L.		
75	<i>Galium verum</i> L. - Жинхэнэ өрөмтүүл	Sol	1
29	<i>Campanulaceae</i> Juss. - Хонхон цэцэгтний овог		
65	<i>Adenophora</i> Fisch.		
76	<i>Adenophora stenanthina</i> (Ldb.) Kitag. - Нарийн цэцэгт хонхлой	Sol	1
30	<i>Asteraceae</i> Dumort. -Гол гэсэртэний овог		

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

66	<i>Heteropappus</i> Less.		
77	<i>Heteropappus hispidus</i> (Thunbg.) Less.- Арзгар согсоот	Sol	1, 2, 3, 4
67	<i>Artemisia</i> L.		
78	<i>Artemisia mongolica</i> Fisch. ex Nakai -Монгол шарилж	Sol	4
79	<i>Artemisia frigida</i> Willd.-Агь	Cop ³	1, 2, 4,
80	<i>Artemisia Sieversiana</i> Willd.-Сиверсийн шарилж	Cop ¹	1, 6, 10, 12, 14, 15
81	<i>Artemisia Adamsii</i> Bess.-Адамсын шарилж	Cop ¹	4, 8, 10, 15
82	<i>Artemisia scoparia</i> Waldst. et Kit.-Ямаан шарилж	Cop ¹	1, 4, 8
83	<i>Artemisia dracuncululus</i> L.-Ишгэн шарилж	Cop ¹	1, 8
84	<i>Artemisia anethifolia</i> Web. ex Stechm.- Божмог шарилж	Cop ¹	1, 3
85	<i>Artemisia palustris</i> L.- Намгийн шарилж	Cop ¹	1, 4, 8, 13
86	<i>Artemisia glauca</i> Pall.- Саарал шарилж	Cop ¹	1, 4
68	<i>Serratula</i> L.		
87	<i>Serratula centauroides</i> L.-Хонгорзуллаг хонгорзалаа	Sol	1
69	<i>Saussurea</i> DC.		
88	<i>Saussurea dahurica</i> Adams.-Дагуур банздоо	Sol	4, 11
89	<i>Saussurea amara</i> DC.-Гашуун банздоо	Cop ¹	3, 13
70	<i>Taraxacum</i>		
90	<i>Taraxacum dissectum</i> (Ldb.) Ldb.- Цуулбар багваахай	Cop ¹	1, 6, 8
71	<i>Crepis</i> L.		
91	<i>Crepis crocea</i> (Lam.) Babcs.-Гүргэм- шар банга	Sol	4, 11
	30 овог, 71 төрөл, 91 зүйл		

Ургамлын ангиллын үндсэн бүлгийн бүтэц. Уг талбайд бүртгэгдсэн зүйл ургамлын ангиллын үндсэн бүлгүүдийн бүтцийг авч үзэхэд ойм, шивэрсэн, шивлээ, хүрээний хүрээний зүйл ургамалгүй, нүцгэн үртэний 1зүйл, далд үртэний хүрээний 90 зүйл (үүнээс нэг талтан 17 зүйл, хос талтан 73 зүйл) байна (хүснэгт 8) [10].

Хүснэгт 8. Өлзийт сумын суурьшлын бүсийн талбайн ургамлуудын ангиллын үндсэн бүлгийн бүтэц

Ангиллын үндсэн бүлгүүдийн нэр	Овгийн тоо	Төрлийн тоо	Зүйлийн	
			тоо	эзлэх хувь (%)
Нүцгэн үртний хүрээ	1	1	1	1.1
Далд үртний хүрээ	29	70	90	98.9
Үүнээс:				

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

а. Нэг талт үрт ургамлын анги	4	15	17	18.68
б. Хос талт үрт ургамлын анги	25	55	73	80.22

Энд бүртгэгдсэн ургамлаас гол гэсэртэн, үетэн, буурцагтан, сарнай, шүхэртэн, уруул цэцэгтэн, лууль, тонолжин цэцэгтэн, иршимбийн овгууд нь төрөл, зүйлийн тоогоор эхний 5 –д жагсаж байгаа [9, 10] бөгөөд бусад овгууд нэгээс гурван зүйлтэй байна. Эхний 9 овогт багтах зүйл ургамлууд тус талбай орчмын бүх зүйлийн ихэнхийг буюу 71.39% -ийг бүрдүүлж байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Өлзийт сумын суурьшлын бүсийн талбайд бүртгэсэн ургамлын ангиллын бүтэц

№	Овог	Төрлийн тоо	Зүйлийн тоо	Эзлэх хувь, %
1	<i>Asteraceae</i> Dumort. -Гол гэсэртэний овог	6	15	16.48
2	<i>Gramineae</i> Juss.-Үетэний овог	12	14	15.38
3	<i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог	4	8	8.79
4	<i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог	5	8	8.79
5	<i>Umbelliferae</i> Juss. – Шүхэртэний овог	4	5	5.49
6	<i>Labiaceae</i> Lindl.- Уруул цэцэгтэний овог	5	5	5.49
7	<i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог	4	4	4.39
8	Тонолжин цэцэгтэний овог (<i>Cruciferae</i> Juss.)	3	3	3.29
9	<i>Scrophulariaceae</i> Juss. –Иршимбийн овог	3	3	3.29
	<i>Veronica L.</i>	46	65	71.39

Ургамлын амьдралын хэлбэр. Өвөрхангай аймгийн Өлзийт сумын суурьшлын бүсийн 323,9 га талбайд ургаж байгаа 91 зүйл ургамлын амьдралын хэлбэрээр ялгахад 18 зүйл нэг наст өвслөг ургамал (19.78%), 70 зүйл олон наст өвслөг ургамал (76.92%), 53 зүйл сөөг, заримдаг сөөгөнцөр ургамал (3.29%), 9 зүйл тарьмал од, сөөг (9.89%), байна.




График 3. Ургамлын амьдралын хэлбэр

Ургамлын ач холбогдол ба хор холбогдол. Өвөрхангай аймгийн Өлзийт сумын суурьшлын бүсийн талбай дахь бүх зүйл ургамлаас 29 овгийн 50 төрлийн 78 зүйл бэлчээрийн (85.71%), 15 овгийн 30 төрлийн 36 зүйл эмийн ашигт ургамал (39.56%), 13 овгийн 22 төрлийн 29 зүйл хөл газрын ургамал (31.87%) бүртгэгдсэн [4, 5, 10, 12] байна (хүснэгт 10).

Хүснэгт 10. Өлзийт сумын суурьшлын бүсийн талбай дахь зүйлийн бүрдлийн онцлог

Ач холбогдол ба хор холбогдол	Ангилал зүйн нэгж			Эзлэх хувь
	овог	төрөл	зүйл	
Бэлчээр тэжээлийн ургамал	29	50	78	85.71%
Эмийн ашигт ургамал	15	30	36	39.56%
Хөл газрын ургамал	13	22	29	31.87%

Бэлчээрийн ургамлаас малд онц сайн идэмжтэй Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), Нугын биелэг өвс (*Poa pratensis* L.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Нангиад түнгэ (*Leymus chinensis* (Trin.) Tzvel.), Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Ахарсорт арвай (*Hordeum brevisubulatum* (Trin.) link.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Shult.), Агь (*Artemisia frigida* Willd.), Жижиг навчит харгана (*Caragana microphylla* (Pall) Lam.), Нумраа хунчир (*Astragalus adsurgens* Pall.), зэрэг ургамлууд байна.

Ургамал хамгаалал. Ургамал судлаач У.Лигаа, Ш.Дариймаа, П.Цэрэннадмид, төслийн багийн гишүүд Н.Жанчивдорж, У.Сарангэрэл, Б.Бат-Энэрэл нарын хамт

(2008 онд) Монгол орны нэн ховор ургамлын зурагт лавлахад 53 овог, 99 төрлийн 133 зүйл ургамал бүртгэсэн байдаг. 2009 онд У.Лигаа ахлагчтай эрдэмтэн судлаач Ш.Дариймаа, Н.Жанчивдорж, У.Сарангэрэл, Х.Жамъяндорж, Б.Бат-Энэрэл нар Монгол орны ховор ургамлын зурагт лавлахад 355 зүйл ховор ургамлын ангилал зүй, таних шинж, тархац, ургах орчин, үржил, нөөц хомсдох шалтгаан, хамгаалах арга хэмжээ зэргийг бичсэн байна [6, 7, 8]. Дээрх судлаачдын бүтээлийн дагуу Өвөрхангай аймгийн Өлзийт сумын суурьшлын бүсийн талбайн дотор ургаж байгаа нэн ховор, ховор, унаган, үлдвэр ургамлын бүртгэлийг гаргахад нэн ховор, ховор ургамал бүртгэгдээгүй, Монголын унаган ургамал Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), Монгол хунчир (*Astragalus mongolicus* Bge.) 2 зүйл, Монголд байгаа завсарын унаган ургамал Дагуур ганга (*Thymus dahuricus* Serg.), Монгол шарилж (*Artemisia mongolica* Fisch. ex Nakai), Утсан ортууз (*Oxytropis filiformis* DC.) 3 зүйл, гуравдагчийн голын татмын ойн үлдвэр ургамал Одой хайлас (*Ulmus pumila* L.), Яшилдуу чацаргана (*Hippophae rhamnoides* L.) бүртгэгдсэн байгаа нь бүх ургамлын **7.67%** нь хамгаалалтанд авах шаардлагатай ургамалд багтаж байна (хүснэгт 11).

Хүснэгт 11. Өлзийт сумын суурьшлын бүсийн талбайд дахь зүйлийн бүрдлийн онцлог


Ургамал хамгааллын статус	Ангилал зүй			Эзлэх хувь
	Овог	Төрөл	Зүйл	
Нэн ховор ургамал	0	0	0	0.0%
Ховор ургамал	0	0	0	0.0%
Монголын унаган ургамал	2	2	2	2.19%
Монголд байгаа завсарын унаган ургамал	3	3	3	3.29%
Үлдвэр ургамал	2	2	2	2.19%
Бүгд				7.67%

Өмнөх хянан баталгааны тайланд хөрсний шинжилгээний ямар нэгэн үзүүлэлт байхгүй тул харьцуулалт хийх боломжгүй байсан.

ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН СУДАЛГАА:

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн тэг гортиг дахь газрын хөрсний онцлог шинжийг илрүүлэх зорилготойгоор үндсэн зүсэлт тавьж судалгааг гүйцэтгэв. Дундаж өндөржилт нь далайн түвшнээс дээш 1830 м.

БХБЯамны захиалгаар 2012-2016 оны хооронд “Орхон гидрогео” ХХК-ийн судалгааны ажлын хүрээнд хийгдсэн хөрсний ангиллын зургаас харахад судалгааны талбайд хүрэн хөрс зонхилон тархсан хойд хэсгээр уулын хар хүрэн хөрс, Хүйсийн голын эргээр нугын хүрэн хөрс тарсан байна (Зураг 9).



Зураг 9. Хөрсний зураг, “Орхон гидрогео” ХХК

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн тэг гортигийн хэмжээнд нийт 18 мониторингийн цэгт хөрсний зүсэлт хийж, газар ашиглалтын төрөл, ургамалан бүрхэвчнээс хамааруулан 15 шинжилгээг хийлгэсэн. Үүнд 8 цэгт агрохимийн шинжилгээ, 6 цэгт эрүүл ахуй микробиологийн шинжилгээ, 1 цэгт хүнд металлын шинжилгээ тус тус хийсэн

Хүснэгт 12. Хөрсний дээжний шинжилгээний төрөл

№	Дээж авсан газар	Дээжний нэр	Агрохими	Микробиологи	Хүнд металл
1	Цэцэрлэгт хүрээлэн	1А	*		

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

2	2022 онд байгуулсан шинэ цэцэрлэгт хүрээлэн	4А 4Б	*		
3	Сумын төв хэсэг, халцгай газар	Х-3		*	
4	Цахилдагт бүлэг	6А	*		
5	Түр хогийн цэг, Нийтийн 00-ийн цэг орчим	Х-4		*	
6	Сумын төвийн урд хэсэг	10А	*		
7	Сумын төвийн зүүн хэсэг	11А	*		
8	Агуйт III гэр хороолол	Х-6		*	
9	Хуучин гэр хороолол	Х-7		*	
10	Гэр хороолол	Х-5		*	
11	Гэр хороолол	15 дэрс	*		
12	Хогийн цэг	Х-8	*	*	
13	Сумын зүүн урд хэсэг, гэр хороолол	11А 11Б	*		
14	Шатахуун түгээх газар	№18			*
Нийт			8	6	1

Агрохимийн шинжилгээний дүнг үндэслэн газрын хянан баталгааны үзүүлэлтийг тус бүр авч үзэхэд Өвөрхангай аймгийн Өлзийт сумын хөрсний механик бүрэлдэхүүн хөнгөн шавранцараас дунд шавранцар, хөрсний урвалын орчин сул шүлтлэгээс дунд шүлтлэг, хөрсний ялзмагийн агууламж 0.56-1.52 буюу маш бага агууламжтай байна.

Хүснэгт 13. Газрын хянан баталгааны үзүүлэлт (агрохими)


№	Дээж авсан газар	Дээжний нэр	Хөрсний механик бүрэлдэхүүн	Хөрсний рН	Хөрсний ялзмагт үеийн зузаан	Хөрсний ялзмагийн агууламж
1	Цэцэрлэгт хүрээлэн	1А	Дунд шавранцар	8.19, дунд шүлтлэг	-	1.08
2	2022 онд байгуулсан шинэ	4А 4Б	Хөнгөн шавранцар	7.9, сул шүлтлэг	0-5 см	1.3

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

	цэцэрлэгт хүрээлэн					
3	Цахилдагт бүлэг	6A	Хөнгөн шавранцар	7.8, сул шүлтлэг	0-10 см	0.56
4	Сумын төвийн урд хэсэг	10A	Хөнгөн шавранцар	8.13, дунд шүлтлэг	0-6см	0.58
5	Сумын төвийн зүүн хэсэг	11A	Дунд шавранцар	7.98, сул шүлтлэг	0-5 см	0.51
6	Гэр хороолол	15	Хөнгөн шавранцар	7.23, сул шүлтлэг	0-10 см	1.6
7	Хогийн цэг	№16	Хөнгөн шавранцар	7.4, сул шүлтлэг	0-10 см	1.49
8	Сумын зүүн урд хэсэг, гэр хороолол	11A	Хөнгөн шавранцар	7.27, сул шүлтлэг	0-13 см	1.52

Хөрсний шинжилгээний дүнгээс харахад биологийн бохирдлын хувьд нийт нянгийн тоо нь бохирдолтой, гэдэсний савханцар их бохирдолтой, перфрингенс-ийн таньц үзсэн үр дүнгээс их бохирдолтой, гэдэсний бүлгийн эмгэг төрөгчдөөс Klebsiella таньц илэрсэн байна.

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан



Зураг 10. Өлзийт сумын төвийн хөрсний тархалт, 2022 он

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын газрын хянан баталгааны хээрийн судалгаагаар тус сумын нутагт жинхэнэ хүрэн хөрс 27.2 га (8.4%), уулын хүрэн хөрс 116,7 га (36%), хээрийн хар шороон хөрс 131.1 га (40.5%), цайвар хүрэн хөрс 48,7 (15%) га газарт тархсан байна. Өмнөх хянан баталгааны тайланд хөрсний шинжилгээний ямар нэгэн үзүүлэлт байхгүй тул харьцуулалт хийх боломжгүй байсан ч хөрсний хамгийн сүүлийн зургаас харахад цайвар хүрэн хөрс нэмэгдэж, бусад ангиллууд нь таарч байна.

Хүснэгт 14. Газрын хянан баталгааны үзүүлэлт (Хөрсний эрүүл ахуй)

№	Дээж авсан газар	Дээж ний нэр	Нянгийн тоо	Гэдэсний савханцрын титр E.coli	Анаэроб Cl.perfringens	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч, Salmonella, Shigella
1	Сумын төв хэсэг, халцгай газар	№5	$3 \cdot 10^7$	0.001	0.1	Илрээгүй

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

2	Түр хогийн цэг, Нийтийн 00-ийн цэг орчим	№8	18*10 ⁷	0.000001	0.0001	Klebsiella илрэв
3	Агуйт III гэр хороолол	№12	38*10 ⁷	0.00001	0.01	Илрээгүй
4	Хуучин гэр хороолол	№13	9*10 ⁶	0.001	0.01	Илрээгүй
5	Гэр хороолол	№14	4*10 ⁵	0.0001	0.001	Илрээгүй
6	Хогийн цэг	№16	31*10 ⁷	0.00001	0.0001	Илрээгүй

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээгээр хянан баталгааны сүлжээний зургийн 5,8,11,12,13,14,16-р нэгж талбаруудад гэдэсний эмгэг төрөгч нянгаар ямар нэгэн хэмжээгээр бохирдсон байна.

Газрын даамал Б.Гансүхийн хүсэлтээр ундны усны болон мод услахаар барьсан 2 худгаас эрүүл ахуй шинжилгээг авсан.



Зураг 11, 12. Ундны худаг, Мод усалдаг худаг

Худгийн усны шинжилгээг “Микро Ворлд” лабораторид шинжлүүлэхэд эдгээр худгийн ус нь бохирдолтой гарсан бөгөөд тухайн худгаас хүн ам ундны ус хэрэглэхгүй байхыг зөвлөж байна.

Хүснэгт 15. Худгийн усны эрүүл ахуйн үзүүлэлт


№	Сорилтын аргын тэмдэглэлгээ	Сорилтын үзүүлэлтүү, хэмжих нэгж	Шаардлага	Худаг 1	Худаг 2
1	MNS ISO 6222:1998	Бичил биетний ерөнхий тоо /1 мл-т/	100	298	300+

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

2	MNS ISO 9308:1998	Халуунд тэсвэртэй гэдэсний савханцар <i>E.soli</i> /100 мл-т/	0	27	21
3	MNS ISO 19250:2017	Salmonella spp /100 мл-т/	0	0	0
4	MNS ISO 6461:1999	Сульфит задлагч агааргүйтэн /100 мл-т/	0	0	0

ДӨРӨВ. НЭГЖ ТАЛБАРЫН СҮЛЖЭЭНИЙ ЗУРАГЛАЛ

Төлөвлөгөөт хянан баталгааны ажлын хүрээнд Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газар ашиглалт, газрын эвдрэл, доройтлыг тогтоох чиглэлээр нэгж талбарын төлөв байдал, чанарыг тогтоох шалгуур үзүүлэлтийн дагуу хээрийн хэмжилт судалгаа явуулж фото зургаар баримтжуулж ажилласан. Дэд нэгж талбарыг үүсгэхдээ сумын төвийн үйлдвэрлэл, барилга байгууламжийн байршлын онцлогийг харгалзан 16 нэгж талбарт хуваан, хилийн цэсийн гадна 1 нэгж талбар /хогийн цэг/ судалгааны ажлыг гүйцэтгэж, хянан баталгааны сүлжээний зураг, 17 нэгж талбарын зураг, паспорт, тайлан бичих ажлууд хийгдлээ.



Зураг 13. Өлзийт сумын хот тосгон бусад суурин газрын хянан баталгааны сүлжээний зураг

Нэгж талбарыг сумын тэг гортигийн хилийн цэсийг ашиглан хуваасан бөгөөд дугаарлалтыг БХБ-ын сайдын 2019 онын 2 сарын 22-ны өдрийн 34-р тоот тушаалын 3-р хавсралтаар баталсан “Хот тосгон, бусад суурин газрын төлөв


байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам"-ын дагуу кодолж дугаарлалаа.

Хүснэгт 16. Нэгж талбарт хуваалт

№	Нэгж талбарын дугаар	Талбай, га	Газар ашиглалтын зориулалт	Ургамалжил	Хөрсний хэв шинж
1	C62340100001	0,28	Ногоон байгууламж	Үетэн-алаг өвс-агьт	Хээрийн хар шороон хөрс
2	C62340100002	27,23	Эзэмшил ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөтэй газар	Үетэн-улалж -цахилдаг - алаг өвст	Жинхэнэ хүрэн хөрс
3	C62340100003	0,2	Ногоон байгууламж	Хиаг -алаг өвст	Хээрийн хар шороон хөрс
4	C62340100004	24,52	Холимог ашиглалт	Үетэн-алаг өвс-агьт	Хээрийн хар шороон хөрс
5	C62340100005	9,77	Нийтийн эзэмшлийн газар	Ургамлан нөмрөггүй болсон газар	Цайвар хүрэн хөрс
6	C62340100006	0,66	Нийтийн эзэмшлийн газар	Үетэн-улалж -цахилдаг - алаг өвст	Хээрийн хар шороон хөрс
7	C62340100007	4,12	Эзэмшил ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөтэй газар	Ерхөг -хялгана-агьт	Уулын хүрэн хөрс
8	C62340100008	0,12	Түр хогийн цэг	Хиаг-шарилжит, Үетэн-улалж -цахилдаг	Хээрийн хар шороон хөрс
9	C62340100010	32,97	Эзэмшил ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөтэй газар	Үетэн-улалж - алаг өвст	Уулын хүрэн хөрс
10	C62340100011	23,71	Эзэмшил ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөтэй газар	Үетэн-чулуусаг алаг өвст	Хээрийн хар шороон хөрс
11	C62340100012	18,21	Гэр хороолол	Хог ургамалт үүсмэл бүлгэмдэл	Хээрийн хар шороон хөрс
12	C62340100013	53,46	Гэр хороолол	Үетэн-улалж -хог ургамалт	Хээрийн хар шороон хөрс
13	C62340100014	8,9	Гэр хороолол	Хиаг-хог ургамалт	Цайвар хүрэн хөрс
14	C62340100015	39,82	Гэр хороолол	Жижиг улалж -хиаг-хог ургамалт, дэрст	Хээрийн хар шороон хөрс
15	C62340100016	1,21	Хогийн төв цэг	Хог ургамал -үетэн-агьт	Уулын хүрэн хөрс
16	C62340100017	78,4	Гэр хороолол	Үетэн-чулуусаг алаг өвст	Уулын хүрэн хөрс
17	C62340100018	0,2	Шатахуун түгээх газар	Жижиг улалж -хиаг-хог ургамалт, дэрст	Хээрийн хар шороон хөрс

4.1 С62340100001 НЭГЖ ТАЛБАР ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН

Сумын төв байгуулсан цэцэрлэгт хүрээлэнг нэг нэгж талбар болгон үзсэн. Нийт талбайн хэмжээ 0,28 га. Энэ цэцэрлэгт хүрээлэн сумын төвийн хамгийн ургамалан бүрхвэч ихтэй, ургамал, модлогийн тоогоор хамгийн олон үлгэр жишээ болох талбар юм (Зураг 14).



Зураг 14. Хянан баталгааны 1-р нэгж талбарын зураг

Үетэн-алаг өвс-агьт (128/Х-II-2-7) бүлгэмдэлийн (1-р цэг) 100м²-д үетнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha* (Ldb.) Schult.), Соргүй согоовор (*Bromus inermis* Leyss.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Нугын биелэг өвс (*Poa pratensis* L.), Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Нарийн сорвоо (*Calamagrostis macilenta* (Griseb.) Litv.), Сибирь цагаан суль (*Elymus sibiricus* L.), Гялгар дэрс (*Achnatherum splendens* (Trin.) Nevski.) болон Агь (*Artemisia frigida* Willd.) зонхилж, улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.), сонгиноос Эдуардын сонгино (*Allium eduardii* Stearn.), алаг өвснөөс Нарийн навчит тарна (*Polygonum angustifolium* Pall.), Хялгасан дэвхэргийн цагаан (*Arenaria cappilaris* Poir.), Мөлхөө

шээрэнгэ (*Silene repens* Patr.), Зөөлөн навчит үлд өвс (*Orostachys malacophylla* (Pall.) Fisch.), Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Марал навчит гичгэнэ (*Potentilla tanacetifolia* Willd. ex Schlecht.), Эмийн сөд (*Sanguisorba officinalis* L.), Буриад гоньд (*Carum buriaticum* Turcz.), Хависхана навчит бэриш (*Bupleurum scorzonerifolium* Willd.), Шивүүрт жав (*Peucedanum hystrix* Bge.), Хэвтээ дэгд (*Gentiana decumbens* L.), Царсан гүүн хөх (*Scutellaria scordifolia* Fisch ex Schrank), Буурал гандбадраа (*Veronica incana* L.), Жинхэнэ өрөмтүүл (*Galium verum* L.), Нарийн цэцэгт хонхлой



Зураг 15,16. Ургамлын мониторинг М 1.

Өвөрхангай аймаг, Өлзийт сум, Цэцэрлэгт хүрээлэн

Үетэн-алаг өвс – агт бүлгэмдэл

N 46°36'36.15"; E 103°32'53.85"; h 1812;

(*Adenophora stenanthina* (Ldb.) Kitag.), Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), Хонгорзуллаг хонгорзалаа (*Serratula centauroides* L.), Цуулбар багваахай (*Taraxacum dissectum* (Ldb.) Ldb.), буурцагтанаас Юлдэн тарваган шийр (*Thermopsis lanceolata* R.Br.), Шар царгас (*Medicago falcata* L.), Нумраа хунчир (*Astragalus adsurgens* Pall.), Монгол хунчир (*Astragalus mongolicus* Bge.), талхлагдлын заагуур ургамлаас Бүхэл навчит багдай (*Dontostemon integrifolius* (L.) C.A.Mey.), Хогийн цангуу (*Lepidium ruderales* L.), Замын таван салаа (*Plantago depressa* Willd.), Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.), Саарал шарилж (*Artemisia glauca* Pall.), Сиверсийн шарилж (*Artemisia Sieversiana* Willd.), Ишгэн шарилж (*Artemisia dracuncululus* L.), Божмог шарилж (*Artemisia anethifolia* Web. ex Stechm.), модноос Сибирь шинэс (*Larix sibirica* Ldb.), Анхилуун улиас (*Populus suaveolens* Fisch.), Одой хайлас (*Ulmus pumila* L.), Хуурамч таван дохиурт бургас (*Salix pseudopentandra* Flod.), Миабейн бургас (*Salix Miyabeana* Seemen.), Гоо улаалзгана (*Ribes pulchellum* Turcz.), Шар хуайс (*Caragana arborescens* Lam.), Яшилдуу чацаргана (*Hippophae rhamnoides* L.) ургасан, нийт 22 овог, 43төрөл, 52

зүйл ургамал ургасан, 1м²-д 8 -10 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 85.0%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 4.4% эзэлж, нийт бүрхэцэд халцгай газар 15.0% байна (Зураг 15,16, Хүснэгт 17).

Хүснэгт 17. Үетэн-алаг өвс–агьт ургамлан нөмрөгийн төлөв байдал

Ургамалжлын хэв шинж	Үзүүлэлт							Ургац/га
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	
Үетэн-алаг өвс–агьт	1 м ² талбайд,	1 м ² талбайд,	100 м ² талбайд					
Давталт 1	85	8	25	5	15	-	-	1.95
Давталт 2	80	8	35	4	20	-	-	1.91
Давталт 3	90	10	23	3	10	-	-	1.57
Давталт 4	92	10	32	6	8	-	-	2.03
Давталт 5	78	8	30	4	22	-	-	2.05
Дундаж	85.0	8-10	25 -53	4.4	15.0	-	-	1.902

Үетэн-алаг өвс–агьт ургамалт бүлгэмдэлийн га–ийн ургац 1.902 цн, үүнээс үетэн 0.848 цн, алаг өвс 0.412 цн, агь 0.642 цн байна (хүснэгт 18).

Хүснэгт 18. Үетэн-алаг өвс–агьт бүлгэмдэлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	8.5	8.1	10.1	6.5	9.2	42.4	8.48	0.848
Алаг өвс	3.5	4.2	2.1	5.3	5.5	4.12	4.12	0.412
Агьт	7.5	6.8	3.5	8.5	5.8	6.42	6.42	0.642
Нийт	19.5	19.1	15.7	20.3	20.5	19.02	19.02	1.902

Хээрийн хар шороон хөрстэй. Хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдээс авч үзвэл урвалын орчин дунд шүлтлэг, ялзмагийн агуулалт маш бага, хөдөлгөөнт элементүүдийг хөрсний хангамжийн зэргээр авч үзвэл нитрат азот маш бага, хөдөлгөөнт фосфор дунд, солилцох кали дунд гэсэн хангамжтай байна. (хүснэгт 19).

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

№	Дээжний нэр	pH	Cond, dsm	Давс, %	Ялзмаг, %	CO ₂	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/ 100 гр		
							Ca	Mg	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
1A	Цэцэрлэгт хүрээлэн	8.19	0.11	0.03	1.08	0	22	13	0	2.4	25

Хүснэгт 19. Хөрсний химийн шинж чанар


Хөрсний механик бүрэлдэхүүний задлан шинжилгээний дүнгээс үзэхэд өнгөн үе давхаргад том ширхэгтэй элсний агууламж өндөр буюу физик элсний эзлэх хувь харьцангуй их буюу 64.96 % байна. Харин А үе давхаргад физик шаврын эзлэх хувь 35.04 % байгаа нь тухайн хөрс дунд шавранцар механик бүрэлдэхүүнтэйг илтгэж байна (хүснэгт 20).

Хүснэгт 20. Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээжний нэр	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм							
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
1A	Цэцэрлэгт хүрээлэн	29.99	27.89	31.36	3.48	0.24	5.64	35.04	

4.2 С62340100002 НЭГЖ ТАЛБАР ЦАХИЛДАГТ БҮЛГЭМДЭЛ

Хянан баталгааны сүлжээний зургийн 2-р нэгж талбар нь сумын төвийн хойгуур урсах Хүйсийн голын эргээр тархсан нугын ургамлын шинж болох цахилдаг бүхий газар. Талбайн хэмжээ 27,23 га (зураг 17).



Зураг 17. Хянан баталгааны 2-р нэгж талбарын зураг

Үетэн-улалж -цахилдаг -алаг өвст (202 /Н-II-2-2) бүлгэмдэлийн (6-р цэг) 100м²-д үетнээс Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Ахарсорт арвай (*Hordeum brevisubulatum* (Trin.) link.), Нугын биелэг өвс (*Poa pratensis* L.), улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.) болон Цагаалин цахилдаг (*Iris lactea* Pall.) зонхилж, алаг өвснөөс Галуун гичгэнэ (*Potentilla anserina* L.), Марзны цэгээлж (*Glaux maritima* L.), Замын таван салаа (*Plantago depressa* Willd.), Цуулбар багваахай (*Taraxacum dissectum* (Ldb.) Ldb.), талхлагдлын заагуур ургамлаас Дэлхээ алис (*Axyris prostrata* L.), Шувуун тарна (*Polygonum aviculare* L.), ургасан, нийт 8 овог, 13 төрөл, 13 зүйл ургамал ургасан,

1м²-д 5 -6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 80.6%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 8.2% эзэлж, нийт бүрхэцэд халцгай газар 19.4% байна (Зураг 18,19, Хүснэгт 21).

Хүснэгт 21. Үетэн–улалж -цахилдаг -алаг өвст ургамлан нөмрөгийн төлөв байдал

Ургамалжлын хэв шинж	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	Ургац/га
Үетэн–улалж -цахилдаг -алаг өвст	1 м ² талбайд,	1 м ² талбайд,	100 м ² талбайд					
Давталт 1	75	5	12	5	25	-	-	4.71
Давталт 2	78	6	12	6	22	-	-	4.87
Давталт 3	85	6	13	10	15	-	-	1.62
Давталт 4	79	5	12	9	21	-	-	4.56
Давталт 5	86	6	13	11	14	-	-	4.31
Дундаж	80.6	5-6	12-13	8.2	19.4	-	-	4.014



Зураг 18,19. Ургамлын мониторинг М 6.

Өвөрхангай аймаг, Өлзийт сум, хээржсэн нугын бүлгэмдэл

Үетэн –улалж -цахилдаг -алаг өвст бүлгэмдэл

N 46°36'36.77"; E 103°32'48.85"; h 1817;


Үетэн–улалж -цахилдаг -алаг өвст бүлгэмдэлийн га–ийн ургац 4.014 цн, үүнээс үетэн, улалж 1.32 цн, цахилдаг 2.694 цн байна (хүснэгт 22).

Хүснэгт 22. Үетэн–улалж -цахилдаг -алаг өвст бүлгэмдэлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн, улалж	13.1	15.5	16.2	10.1	11.1	66.0	13.2	1.32
Цахилдаг	34.0	33.2	0.0	35.5	32.0	134.7	26.94	2.694
Нийт	47.1	48.7	16.2	45.6	43.1	200.7	40.14	4.014

4.3 С62340100003 НЭГЖ ТАЛБАР ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ

Хянан баталгааны сүлжээний зургийн 3-р нэгж талбар нь сумын төвийн хүүхдийн цэцэрлэгийн гадуурх цэцэрлэг. Талбайн хэмжээ 0,2 га.



Зураг 20. Хянан баталгааны 3-р нэгж талбарын зураг

Хянаг-алаг өвст (121 /Х-II-1-1) бүлгэмдэлийн (3-р цэг) 100м²-д Мөлхөө хяг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.) зонхилж, үетнээс Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Сибирь цагаан суль (*Elymus sibiricus* L.), Гялгар дэрс (*Achnatherum splendens* (Trin.) Nevski.), алаг өвснөөс Галуун гичгэнэ

(*Potentilla anserina* L.), Өндөр үхэр гоньд (*Sphallerocarpus gracilis* (Bess. ex Trev.) K.-Pol.), Хависхана навчит бэриш (*Bupleurum scorzonerifolium* Willd.), Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), Хонгорзуллаг хонгорзалаа (*Serratula centauroides* L.), Цуулбар багваахай (*Taraxacum dissectum* (Ldb.) Ldb.-), буурцагтанаас Шар царгас (*Medicago falcata* L.), Нумраа хунчир (*Astragalus adsurgens* Pall.), талхлагдлын заагуур ургамлаас Олслиг халгай (*Urtica cannabina* L.), Шувуун тарна (*Polygonum aviculare* L.), Цагаан лууль (*Chenopodium album* L.), Өнхрүүш хамхуул (*Corispermum declinatum* Steph.), Замын таван салаа (*Plantago depressa* Willd.), Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.), Саарал шарилж (*Artemisia glauca* Pall.), Сиверсийн шарилж (*Artemisia Sieversiana* Willd.), Ишгэн шарилж (*Artemisia dracuncululus* L.), Божмог шарилж (*Artemisia anethifolia* Web. ex Stechm.), модноос Анхилуун улиас (*Populus suaveolens* Fisch.), Одой хайлас (*Ulmus pumila* L.), Хуурамч таван дохиурт бургас (*Salix pseudopentandra* Flod.), Шар хуайс (*Caragana arborescens* Lam.), Голтбор (*Syringia josikaea* Jacq. F.) ургасан, нийт 14 овог, 24 төрөл, 28 зүйл ургамал ургасан, 1м²-д 6-8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 85.0%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 4.4% эзэлж, нийт бүрхэцэд халцгай газар 15.0% байна (Зураг 21,22,23, Хүснэгт 23).

Хүснэгт 23. Хиаг -алаг өвст ургамлан нөмрөгийн төлөв байдал

Ургамалжлын хэв шинж	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	Ургац/га
Хиаг - алаг өвст	1 м ² талбайд,	1 м ² талбайд,	100 м ² талбайд					
Давталт 1	78	8	16	23	22	-	-	3.3
Давталт 2	70	6	15	25	30	-	-	3.3
Давталт 3	72	6	25	20	28	-	-	4.25
Давталт 4	80	8	28	30	20	-	-	3.21
Давталт 5	68	7	17	22	32	-	-	3.27
Дундаж	73.6	6-8	15-28	24.0	26.4	-	-	3.466





Зураг 21-23. Ургамлын мониторинг М 3.

Өвөрхангай аймаг, Өлзийт сум, Цэцэрлэг

Хиаг -алаг өвст бүлгэмдэл N 46°36'38.15"; E 103°32'56.96"; h 1822;

2022.07.27.


Хиаг -алаг өвст ургамалт бүлгэмдэлийн га–ийн ургац 3.466 цн, үүнээс хиаг 2.484 цн, алаг өвс 0.982 цн байна (хүснэгт 24).

Хүснэгт 24. Хиаг -алаг өвст бүлгэмдэлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Хиаг	24.5	25.5	24.1	26.5	23.6	124.2	24.84	2.484
Алаг өвс	8.5	7.5	8.4	5.6	9.1	49.1	9.82	0.982
Нийт	33.0	33.0	42.5	32.1	32.7	173.3	34.66	3.466

4.4 С62340100004 НЭГЖ ТАЛБАР ХОЙД ХЭСЭГ

Хянан баталгааны сүлжээний зургийн 4-р нэгж талбар нь сумын төвийн хойд талын хэсэг. Энд хот суурийн газрын мониторингийн цэг 1-ыг байгуулсан. Мөн энэ хэсэгт сумын захиргаа 2022 онд 0,39 га газрыг цэцэрлэгжүүлэхээр хашаа барьсан байгаа нь дараагийн мониторингийн өөрчлөлт харуулах үндсэн цэг болж байгаагаараа давуу талтай. Талбайн хэмжээ 0,2 га.



Зураг 24. Хянан баталгааны 4-р нэгж талбарын зураг

Үетэн-алаг өвс-агьт (128а/Х-II-2-7) бүлгэмдэлийн (4-р цэг) 100м²-д үетнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha* (Ldb.) Schult.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Ленийн ботууль (*Festuca lenensis* Drob.) болон Агь (*Artemisia frigida* Willd.) зонхилж, сонгиноос Дэлхээ сонгино (*Allium prostratum* Trev.), алаг өвснөөс Нарийн навчит тарна (*Polygonum angustifolium* Pall.), Хялгасан дэвхэргийн цагаан (*Arenaria cappilaris* Poir.), Бунгийн яргуй (*Pulsatilla Bungeana* С.А.Мей.), Алтайн түмэн тана (*Chamaerhodos altaica* (Laxm.) Bge.), Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Торгон гичгэнэ (*Potentilla sericea* L.), Налчгар хэрээн хошуу (*Sibbaldianthe adpressa* (Bge.)Juz.), Хоёр ишт бэриш (*Bupleurum bicaule* Helm.), Шивүүрт жав (*Peucedanum hystrix* Bge.), Хэвтээ дэгд (*Gentiana decumbens* L.), Хахуундуу шимэлдэг (*Dracosephalum origanoides* Steph. Ex Willd.), Үсхий нохойн хэл (*Panzeria lanata* (L.) Bge.), Дагуур ганга (*Thymus dahuricus* Serg.), Шар хувилгана (*Pedicularis flava* Pall.), Дагуур хатны цэцэг (*Cymbaria dahurica* L.), Гүргэм- шар банга (*Crepis crocea* (Lam.) Babc.), Дагуур банздоо (*Saussurea dahurica* Adams.), Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), Цуулбар багваахай (*Taraxacum dissectum* (Ldb.) Ldb.), буурцагтанаас Тарваган харгана (*Caragana pugnata* (L.) DC.), Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), Утсан ортууз (*Oxytropis filiformis* DC.), талхлагдлын заагуур ургамлаас Бүхэл навчит багдай (*Dontostemon integrifolius* (L.) С.А.Мей.), Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.), Саарал шарилж (*Artemisia glauca* Pall.), Сиверсийн шарилж (*Artemisia Sieversiana* Willd.), Намгийн шарилж (*Artemisia palustris* L.) Монгол шарилж (*Artemisia mongolica* Fisch. ex Nakai), Адамсын шарилж (*Artemisia Adamsii* Bess.), модноос Анхилуун улиас (*Populus suaveolens* Fisch.), Одой хайлас (*Ulmus pumila* L.), Хуурамч таван дохиурт бургас (*Salix pseudopentandra* Flod.), Миабейн бургас (*Salix Miyabeana* Seemen.), ургасан, нийт 15 овог, 34 төрөл, 42 зүйл ургамал ургасан, 1м²-д 8 -10 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 61.6%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 15.2%

эзэлж, нийт бүрхэцэд хайрга чулуу 5.8%, халцгай газар 33.6% байна (Зураг 24-27, Хүснэгт 25).



Зураг 25-27. Ургамлын мониторинг М 4.

Өвөрхангай аймаг, Өлзийт сум, Шинэ цэцэрлэгт хүрээлэн

Үетэн-алаг өвс –агьт бүлгэмдэл

N 46°36'42.23"; E 103°32'51.93"; h 1808;

Хүснэгт 25. Үетэн-алаг өвс–агьт ургамлан нөмрөгийн төлөв байдал

Ургамалжлын хэв шинж	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хайрга, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	Ургац/га
Үетэн-алаг өвс–агьт	1 м ² талбайд,	1 м ² талбайд,	100 м ² талбайд					
Давталт 1	65	10	42	15	35	5	-	2.03
Давталт 2	60	9	40	10	36	4	-	2.21
Давталт 3	58	8	20	18	34	8	-	2.25
Давталт 4	70	10	30	20	28	2	-	2.13

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

Давталт 5	55	8	25	13	35	10	-	2.33
Дундаж	61.6	8-10	20-42	15.2	33.6	5.8	-	2.19

Үетэн-алаг өвс–агьт ургамалт бүлгэмдэлийн га–ийн ургац 2.19 цн, үүнээс үетэн 1.218 цн, алаг өвс 0.242 цн, агь шарилжит 0.73 цн байна (хүснэгт 26).

Хүснэгт 26. Үетэн-алаг өвс–агьт бүлгэмдэлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	12.0	11.5	13.5	11.3	12.6	60.9	12.18	1.218
Алаг өвс	2.0	1.5	3.5	2.5	2.6	12.1	2.42	0.242
Агь, шарилж	6.3	9.1	5.5	7.5	8.1	36.5	7.3	0.73
Нийт	20.3	22.1	22.5	21.3	23.3	109.5	21.9	2.19

Хүснэгт 27. Хөрсний морфологи бичиглэл

Хөрсний нэр	Хээрийн хар шороон хөрс
	<p>A_{18}^{0-18} см Хүрэн өнгөтэй, өлөн чийгтэй, ургамлын сахлаг үндэстэй, чулуурхаг, шоо дөрвөлжин бүтэцтэй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, шилжилт өнгөөр аажим, профилийн хөгжил сул, 10%-н давсны хүчилд буцлахгүй, шинээр үүссэн шигдсэн бодис байхгүй, нягтавтарт, сүвшил багатай.</p> <p>AB_{2}^{18-20} см.</p>
	<p>В В 14см-с доош. Цайвар хүрэн өнгөтэй, өлөн чийгтэй, чулуу багатай, ургамлын үндэс байхгүй, 10%-ийн давсны хүчилд буцлахгүй.</p>

Хүснэгт 28. Хөрсний химийн шинж чанар

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

№	Дээжний нэр	pH	Cond, dsm	Давс, %	Ялзмаг, %	CO ₂	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр		
							Ca	Mg	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
4А	хашааны дотор	7.9	0.063	0.02	1.3	-	20	12	-	3.2	35
4Б	хашааны гадна	7.78	0.046	0.015	0.78	-	24	14	-	3.1	33

Хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдээс авч үзвэл урвалын орчин сул шүлтлэг, ялзмагийн агуулалт маш бага, хөдөлгөөнт элементүүдийг хөрсний хангамжийн зэргээр авч үзвэл нитрат азот маш бага, хөдөлгөөнт фосфор ихэвтэр, солилцох кали ихэвтэр гэсэн хангамжтай байна. Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүнийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 29. Хөрсний механик бүрэлдэхүүн


№	Дээжний нэр	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
4А	хашааны дотор	21.47	55.53	11.12	3.24	2.76	4.48	25.53
4Б	хашааны гадна	25.81	59.67	3.64	2.88	2.48	4.12	29.42

Хөрсний механик бүрэлдэхүүний задлан шинжилгээний дүнгээс үзэхэд өнгөн үе давхаргад том ширхэгтэй элсний агууламж өндөр буюу физик элсний эзлэх хувь харьцангуй их буюу 74.47 % байна. Харин А үе давхаргад физик шаврын эзлэх хувь 25.53 % байгаа нь тухайн хөрс хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэйг илтгэж байна.

4.5 С62340100005 НЭГЖ ТАЛБАР СУМЫН ХАЛЦГАЙ ГАЗАР

Хянан баталгааны сүлжээний зургийн 5-р нэгж талбар нь сумын төвийн ургамалан бүрхэвчгүй болсон халцгай хэсэг. Талбайн хэмжээ 6,99 га.

ӨВӨРХАНГАЙ /62/ АЙМГИЙН ӨЛЗИЙТ /34/ СУМЫН ХОТ ТОСГОН БУСАД СУУРИН ГАЗРЫН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН БАТАЛГААНЫ С62340100005 НЭГЖ ТАЛБАРЫН ЗУРАГ



Зураг 28. Хянан баталгааны 5-р нэгж талбарын зураг



Зураг 29,30. Ургамлын мониторинг М 5.

Өвөрхангай аймаг, Өлзийт сум, сумын төв хэсэг, халцгай газар
 Ургамлан нөмрөггүй болсон газар
 N 46°36'42.23"; E 103°32'53.8"; h 1821;

Хүснэгт 30. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн

№	Дээжний нэр	Нянгийн тоо MNS:ISO 6341: 2012	Гэдэсний савханцрын титр (E coli) MNS:ISO 5367:2004	Анаэробын (Cl.perfringens) MNS 6341:2012	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч MNS:ISO 6341: 2012
5-р зүсэлт					
№5	Сумын төв хэсэг, халцгай газар	$3 \cdot 10^7$	0.001	0.1	Илрээгүй

Биологийн бохирдлын хувьд нийт нянгийн тоо $3 \cdot 10^7$ байгаа нь бохирдолтой, гэдэсний савханцрын титр дунд бохирдолтой, анаэробын перфрингенсийн 0.1 байгаа нь бохирдолгүй цэвэр гэсэн дүгнэлт гарч байна.

Хүснэгт 31. Хөрсний морфологи бичиглэл


	<p>A $\frac{0-15}{15}$ см Цайвар хүрэн өнгөтэй, өлөн чийгтэй, ургамлын сахлаг үндэстэй, чулуурхаг, шоо дөрвөлжин бүтэцтэй, 7 механик бүрэлдэхүүнтэй, шилжилт өнгөөр аажим, профилийн хөгжил сул, 10%-н давсны хүчилд сул бургиж буцална, шинээр үүссэн шигдсэн бодис байхгүй, нягтавтарт,</p>
--	--

	<p>сүвшил багатай. $AB \frac{15-16}{1}$ см.</p>
	<p>В 16 см-с доош. Цайвар өнгөтэй, өлөн чийгтэй, чулуу багатай, ургамлын үндэс байхгүй, 10%-ийн давсны хүчилд сул бургиж буцална.</p>

4.6 С62340100006 НЭГЖ ТАЛБАР СУРГУУЛЬ

Хянан баталгааны сүлжээний зургийн 6-р нэгж талбар нь сумын сургуулийн гадуурх цэцэрлэгтэй хашаалсан хэсэг. Талбайн хэмжээ 0,66 га. Энд нугын ургамлын нэг төрөл болох цахилдаг ургадаг

ӨВӨРХАНГАЙ /62/ АЙМГИЙН ӨЛЗИЙТ /34/ СУМЫН ХОТ ТОСГОН БУСАД СУУРИН ГАЗРЫН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН БАТАЛГААНЫ С62340100006 НЭГЖ ТАЛБАРЫН ЗУРАГ



Зураг 31. Хянан баталгааны 6-р нэгж талбарын зураг

Үетэн –улалж -цахилдаг -алаг өвст (202 /Н-II-2-2) бүлгэмдэлийн (6, –р цэг) 100м²-д үетэнээс Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Ахарсорт арвай (*Hordeum brevisubulatum* (Trin.) link.), Нугын биелэг өвс (*Poa pratensis* L.), улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.) болон Цагаалин цахилдаг (*Iris lactea* Pall.) зонхилж, алаг өвснөөс Галуун гичгэнэ (*Potentilla anserina* L.), Марзны цэгээлж (*Glaux maritima* L.), Замын таван салаа (*Plantago depressa* Willd.), Цуулбар багваахай (*Taraxacum dissectum* (Ldb.) Ldb.), талхлагдлын заагуур ургамлаас Дэлхээ алис (*Axyris prostrata* L.), Шувуун тарна (*Polygonum aviculare* L.), ургасан, нийт 8 овог, 13 төрөл, 13 зүйл ургамал ургасан, 1м²-д 5 -6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 80.6%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 8.2% эзэлж, нийт бүрхэцэд халцгай газар 19.4% байна (Зураг 32, 33, Хүснэгт 32).

Хүснэгт 32. Үетэн –улалж -цахилдаг -алаг өвст ургамлан нөмрөгийн төлөв байдал

Ургамалжлын хэв шинж	Үзүүлэлт							Ургац/га
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	
Үетэн – улалж цахилдаг алаг өвст	1 м ² талбайд,	1 м ² талбайд,	100 м ² талбайд					
Давталт 1	75	5	12	5	25	-	-	4.71
Давталт 2	78	6	12	6	22	-	-	4.87
Давталт 3	85	6	13	10	15	-	-	1.62
Давталт 4	79	5	12	9	21	-	-	4.56
Давталт 5	86	6	13	11	14	-	-	4.31
Дундаж	80.6	5-6	12-13	8.2	19.4	-	-	4.014

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан



Зураг 32, 33. Ургамлын мониторинг М 6.

Өвөрхангай аймаг, Өлзийт сум, хээржсэн нугын бүлгэмдэл
 Үетэн –улалж -цахилдаг -алаг өвст бүлгэмдэл
 N 46°36'36.77"; E 103°32'48.85": h 1817;
 2022.07.27.

Үетэн–улалж-цахилдаг-алаг өвст бүлгэмдэлийн га–ийн ургац 4.014 цн, үүнээс үетэн, улалж 1.32 цн, цахилдаг 2.694 цн байна (хүснэгт 33).

Хүснэгт 33. Үетэн –улалж -цахилдаг -алаг өвст бүлгэмдэлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн, улалж	13.1	15.5	16.2	10.1	11.1	66.0	13.2	1.32
Цахилдаг	34.0	33.2	0.0	35.5	32.0	134.7	26.94	2.694
Нийт	47.1	48.7	16.2	45.6	43.1	200.7	40.14	4.014

Хүснэгт 34. Хээржсэн нугын хөрсний морфологи бичигчлэл

Хөрсний нэр	Хээрийн хар шороон хөрс
	<p>A $\frac{0-23}{23}$ см Хүрэн өнгөтэй, өлөн чийгтэй, ургамлын сахлаг үндэстэй, чулуу багатай, шоо дөрвөлжин бүтэцтэй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, шилжилт өнгөөр аажим, профилийн хөгжил сул, 10%-н давсны хүчилд буцлахгүй, шинээр үүссэн шигдсэн бодис байхгүй, нягтавтар, сүвшил багатай.</p> <p>AB $\frac{23-25}{2}$ см.</p>

	В 25см-с доош. Цайвар хүрэн өнгөтэй, өлөн чийгтэй, чулуу багатай, ургамлын үндэс байхгүй, 10%-ийн давсны хүчилд буцлахгүй.
--	--

Хүснэгт 35. Хөрсний химийн шинж чанар

№	Дээжний нэр	pH	Cond, dsm	Давс, %	Ялзмаг, %	CO ₂	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр		
							Ca	Mg	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
6А	Цахилдагт бүлгэмдэл	7.8	0.073	0.02	0.56	0	19	12	0	1.9	39

Хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдээс авч үзвэл урвалын орчин сул шүлтлэг, ялзмагийн агуулалт бага, хөдөлгөөнт элементүүдийг хөрсний хангамжийн зэргээр авч үзвэл нитрат азот маш бага, хөдөлгөөнт фосфор дунд, солилцох кали ихэвтэр гэсэн хангамжтай байна. Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүнийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 36. Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээжний нэр	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
6А	Цахилдагт бүлгэмдэл	20.46	59.9	10.16	0.76	1.4	5.92	25.98

Хөрсний механик бүрэлдэхүүний задлан шинжилгээний дүнгээс үзэхэд өнгөн үе давхаргад том ширхэгтэй элсний агууламж өндөр буюу физик элсний эзлэх хувь харьцангуй их буюу 74.02 % байна. Харин А үе давхаргад физик шаврын эзлэх хувь 25.98 % байгаа нь тухайн хөрс хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэйг илтгэж байна.

4.7 С62340100007 НЭГЖ ТАЛБАР ГОЛЫН ХОЙД ХЭСЭГ

Хянан баталгааны сүлжээний зургийн 7-р нэгж талбар нь сумын хойгуур орших Хүйсийн голын арын уулархаг хэсгийн төлөөл. Талбайн хэмжээ 4,12 га. Энд хүн ам суурьшдаггүй, Эзэмшил ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөтэй газар


Үетэн–улалж - алаг өвст (85 /УХ- II-2-1) бүлгэмдэлийн (10–р цэг) 100м²-д үетнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides*

Trin.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.) зонхилж, алаг өвснөөс Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Налчгар хэрээн хошуу (*Sibbaldianthe adpressa* (Bge.) Juz.), Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), буурцагтанаас Тарваган харгана (*Caragana pugnata* (L.) DC.), Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), талхлагдлын заагуур ургамлаас Сиверсийн шарилж (*Artemisia Sieversiana* Willd.), Адамсын шарилж (*Artemisia Adamsii* Bess.) ургасан, нийт 5 овог, 11 төрөл, 12 зүйл ургамал ургасан, 1м²-д 5-8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 72.0%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 11.2% эзэлж, нийт бүрхэцэд хайрга чулуу 1.8%, халцгай газар 26.2% байна хэмээн хянан баталгааны 10-р нэгж талбартай адитган үзэж байна.

4.8 С62340100008 НЭГЖ ТАЛБАР ТҮР ХОГИЙН ЦЭГ, НИЙТИЙН 00–ИЙН ЦЭГ ОРЧИМ

Хянан баталгааны сүлжээний зургийн 8-р нэгж талбар нь сумын төвийн зүүн өмнө орших түр хогийн цэг, нийтийн 00–ийн цэг орчим. Талбайн хэмжээ 4,12 га.

ӨВӨРХАНГАЙ /62/ АЙМГИЙН ӨЛЗИЙТ /34/ СУМЫН ХОТ ТОСГОН БУСАД
СУУРИН ГАЗРЫН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН БАТАЛГААНЫ
С62340100008 НЭГЖ ТАЛБАРЫН ЗУРАГ



Зураг 34. Хянан баталгааны 8-р нэгж талбарын зураг

Хиаг-шарилжит, Үетэн-уулалж -цахилдаг -алаг өвст (121а -202 /X- II-1-1; H-II-2-2) бүлгэмдэлийн (8-р цэг) 100м²-д үетнээс Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Ахарсорт арвай (*Hordeum brevisubulatum* (Trin.) link.), Нугын биелэг өвс (*Poa pratensis* L.), уулалжаас Ширэг уулалж (*Carex duriuscula* C.A.Mey.) болон Цагаалин цахилдаг (*Iris lactea* Pall.), шарилжнаас Адамсын шарилж (*Artemisia Adamsii* Bess.), Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.), Ишгэн шарилж (*Artemisia dracuncululus* L.), Намгийн шарилж (*Artemisia palustris* L.) зонхилж, алаг өвснөөс Галуун гичгэнэ (*Potentilla anserina* L.), Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Марзны цэгээлж (*Glaux maritima* L.), Замын таван салаа (*Plantago depressa* Willd.), Цуулбар багваахай (*Taraxacum dissectum* (Ldb.) Ldb.), талхлагдлын заагуур ургамлаас Дэлхээ алис (*Axyris prostrata* L.),

Шувуун тарна (*Polygonum aviculare* L.), Хогийн цангуу (*Lepidium ruderae* L.), Завсрын ноцгоно (*Lappula intermedia* (Ldb.) M.Pop.) ургасан, нийт 11 овог, 15 төрөл, 20 зүйл ургамал ургасан, 1м²-д 6-8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 72.4%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 9.0% эзэлж, нийт бүрхэцэд халцгай газар 18.6% байна (Зураг 35-38, Хүснэгт 37).



Зураг 35-38. Ургамлын мониторинг М 8.

Өвөрхангай аймаг, Өлзийт сум, Түр хогийн цэг, Нийтийн 00-ийн цэг орчим
Хиаг –шарилжит, Үетэн –улалж -цахилдаг -алаг өвст бүлгэмдэл
N 46°36'32.9"; E 103°32'45.33"; h 1817;

Хүснэгт 37. Хиаг–шарилжит ургамлан нөмрөгийн төлөв байдал

Ургамалжлын хэв шинж	Үзүүлэлт						Ургац/га
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо	Талхлагдлын заагуур	Халцгай газрын хэмжээ,	Хад, чулууны	Хагдны хэмжээ %	

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

Хиаг–шарилжит	1 м ² талбайд,	1 м ² талбайд,	100 м ² талбайд	ургамлын бүрхэц, %	%	хэмжээ, %		
Давталт 1	70	6	15	20	22	8	-	2.22
Давталт 2	78	7	16	35	15	7	-	2.01
Давталт 3	68	6	15	30	22	10	-	1.97
Давталт 4	65	6	18	31	24	11	-	2.56
Давталт 5	81	8	20	38	10	9	-	2.28
Дундаж	72.4	6-8	15-20	30.8	18.6	9.0	-	2.214

Хиаг–шарилжит ургамалт бүлгэмдэлийн га–ийн ургац 2.214 цн, үүнээс хиаг 1.158 цн, шарилж 10.56 цн байна (хүснэгт 38).

Хүснэгт 38. Хиаг–шарилжит бүлгэмдэлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Хиаг	10.1	11.5	10.5	13.5	12.3	57.9	11.58	1.158
Шарилж	12.1	8.6	9.2	12.4	10.5	52.8	10.56	1.056
Нийт	22.2	20.1	19.7	25.9	22.8	110.7	22.14	2.214


Хүснэгт 39. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн

№	Дээжний нэр	Нянгийн тоо MNS:ISO 6341: 2012	Гэдэсний савханцрын титр (E coli) MNS:ISO 5367:2004	Анаэробын (Cl.perfringens) MNS 6341:2012	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч MNS:ISO 6341: 2012
8-р зүсэлт					
№8	Түр хогийн цэг, Нийтийн 00-ийн цэг орчим	18*10 ⁷	0.000001	0.0001	Klebsiella илрэв.

Биологийн бохирдлын хувьд нийт нянгийн тоо 18*10⁷ байгаа нь бохирдолтой, гэдэсний савханцар их бохирдолтой, перфрингенсийн таньц үзсэн үр дүнгээс харахад их бохирдолтой гэсэн дүгнэлт гарч байна.

4.9 С62340100010 НЭГЖ ТАЛБАР СУМЫН ЗҮҮН УРД ХЭСЭГ

Хянан баталгааны сүлжээний зургийн 10-р нэгж талбар нь сумын төвийн өмнө хэсэг. Талбайн хэмжээ 32.9 га. Энд хүн ам суурьшдаггүй, сумын төвийн урд уулын орчим газар.



Зураг 39. Хянан баталгааны 10-р нэгж талбарын зураг

Үетэн-уулалж - алаг өвст (85 /УХ- II-2-1) бүлгэмдэлийн (10-р цэг) 100м²-д үетнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.V.), уулалжаас Ширэг уулалж (*Carex duriuscula* C.A.Mey.) зонхилж, алаг өвснөөс Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Налчгар хэрээн хошуу (*Sibbaldianthe adpressa* (Vge.) Juz.), Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), буурцагтанаас Тарваган харгана (*Caragana pugnata* (L.) DC.), Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), талхлагдлын заагуур ургамлаас Сиверсийн шарилж (*Artemisia Sieversiana* Willd.), Адамсын шарилж (*Artemisia Adamsii* Bess.) ургасан, нийт 5 овог, 11 төрөл, 12 зүйл ургамал ургасан, 1м²-д 5-8 орчим зүйл тааралдаж

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын тайлан

байв. Ургамлын тусгаг бүрхэц 72.0%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 11.2% эзэлж, нийт бүрхэцэд хайрга чулуу 1.8%, халцгай газар 26.2% байна (Зураг 40-44, Хүснэгт 40).

Хүснэгт 40. Үетэн–улалж - алаг өвст ургамлан нөмрөгийн төлөв байдал

Ургамалжлын хэв шинж	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	Ургац/га
Үетэн–улалж - алаг өвст	1 м ² талбайд,	1 м ² талбайд,	100 м ² талбайд					
Давталт 1	71	8	12	10	28	1	-	1.97
Давталт 2	68	5	12	8	31	1	-	2.0
Давталт 3	67	6	12	11	31	2	-	1.91
Давталт 4	78	8	12	12	20	2	-	1.92
Давталт 5	76	7	12	15	21	3	-	1.57
Дундаж	72.0	5-8	12	11.2	26.2	1.8	-	1.874



Зураг 40-44. Ургамлын мониторинг М 10.

Өвөрхангай аймаг, Өлзийт сум, Түр хогийн цэг, Сумын урд тал

Үетэн –улалж - алаг өвст бүлгэмдэл

N 46°36'31.39"; E 103°32'48.4"; h 1821;

Үетэн–улалж - алаг өвст ургамалт бүлгэмдэлийн га–ийн ургац 1.874 цн, үүнээс үетэн, улалж 1.54 цн, алаг өвс 0.334 цн байна (хүснэгт 41).

Хүснэгт 41. Үетэн–улалж - алаг өвст бүлгэмдэлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн, улалж	15.6	16.5	14.6	17.1	13.2	77.0	15.4	1.54
Алаг өвс	4.1	3.5	4.5	2.1	2.5	16.7	3.34	0.334
Нийт	19.7	20.0	19.1	19.2	15.7	93.7	18.74	1.874

Хүснэгт 42. Хөрсний морфологи бичиглэл

Хөрсний нэр	Уулын хүрэн хөрс
	<p>А $\frac{0-22}{22}$ см Хүрэн өнгөтэй, өлөн чийгтэй, ургамлын сахлаг үндэстэй, чулуурхаг, шоо дөрвөлжин бүтэцтэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, шилжилт өнгөөр аажим, профилийн хөгжил сул, 10%-н давсны хүчилд буцлахгүй, шинээр үүссэн шигдсэн бодис байхгүй, нягтавттар, сүвшил багатай.</p>
	<p>AB $\frac{12-14}{2}$ см.</p> <p>В 14см-с доош. Цайвар хүрэн өнгөтэй, өлөн чийгтэй, чулуу багатай, ургамлын үндэс байхгүй, 10%-ийн давсны хүчилд буцлахгүй.</p>

Хүснэгт 43. Хөрсний химийн шинж чанар

№	Дээжний нэр	pH	Cond, dsm	Давс, %	Ялзмаг, %	CO ₂	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр		
							Ca	Mg	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
10 А	Сумын төвийн урд хэсэг	8.13	0.054	0.015	0.58	0	20	13	0	2.5	43

Хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдээс авч үзвэл урвалын орчин дунд шүлтлэг, ялзмагийн агуулалт маш бага, хөдөлгөөнт элементүүдийг хөрсний хангамжийн зэргээр авч үзвэл нитрат азот маш бага, хөдөлгөөнт фосфор дунд, солилцох кали их гэсэн хангамжтай байна. Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүнийг дараах хүснэгт 44-ээр харуулав.

Хүснэгт 44. Хөрсний механик бүрэлдэхүүн


№	Дээжний нэр	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм							
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
10А	Сумын төвийн урд хэсэг	14.59	64.65	11.28	1.96	0.16	5.96	20.27	

Хөрсний механик бүрэлдэхүүний задлан шинжилгээний дүнгээс үзэхэд өнгөн үе давхаргад том ширхэгтэй элсний агууламж өндөр буюу физик элсний эзлэх хувь харьцангуй их буюу 79.93 % байна. Харин А үе давхаргад физик шаврын эзлэх хувь 20.07 % байгаа нь тухайн хөрс хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэйг илтгэж байна.

4.10 С62340100011 НЭГЖ ТАЛБАР СУМЫН ЗҮҮН УРД ХЭСЭГ

Хянан баталгааны сүлжээний зургийн 11-р нэгж талбар нь сумын төвийн зүүн хэсэг. Талбайн хэмжээ 23,7 га. Энд хүн ам суурьшдаггүй.

ӨВӨРХАНГАЙ /62/ АЙМГИЙН ӨЛЗИЙТ /34/ СУМЫН ХОТ ТОСГОН БУСАД СУУРИН ГАЗРЫН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН БАТАЛГААНЫ С62340100011 НЭГЖ ТАЛБАРЫН ЗУРАГ



Зураг 45. Хянан баталгааны 11-р нэгж талбарын зураг

Үетэн-чулуусаг алаг өвст (128 /X-II-2-7) бүлгэмдэлийн (11–р цэг) 100м²-д үетнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha* (Ldb.) Schult.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Ленийн ботууль (*Festuca lenensis* Drob.) зонхилж, Хялгасан дэвхэргийн цагаан (*Arenaria capillaris* Poir.), Торгон гичгэнэ (*Potentilla sericea* L.), Налчгар хэрээн хошуу (*Sibbaldianthe adpressa* (Vge.) Juz.), Хоёр ишт бэриш (*Vupleurum bicaule* Helm.), Дагуур ганга (*Thymus dahuricus* Serg.), Дагуур банздоо (*Saussurea dahurica* Adams.), Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), Гүргэм- шар банга (*Crepis crocea* (Lam.) Babc.), буурцагтанаас Тарваган харгана (*Caragana pugnata* (L.) DC.), Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), Утсан ортууз (*Oxytropis filiformis* DC.), шарилжнаас Агь (*Artemisia frigida* Willd.) ургасан, нийт 6 овог, 19 төрөл, 19 зүйл ургамал ургасан, 1м²-д 7 -8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 61.8%, түүнээс талхлагдлын заагуур ургамал 3.2% эзэлж, нийт бүрхэцэд хайрга чулуу 12.8%, халцгай газар 25.4% байна (Зураг 46,47, Хүснэгт 45).



Зураг 46,47. Ургамлын мониторинг М 11.

